



INSTITUTE  
**NRAE**

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХҮЙН  
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН**



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



# БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ

**МОНГОЛ УЛСЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД  
ЗОРИУЛСАН ЦОГЦ ГАРЫН АВЛАГА**

**2022 ОН**

Published by

**giz** Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



# БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ

МОНГОЛ УЛСЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД  
ЗОРИУЛСАН ЦОГЦ ГАРЫН АВЛАГА

2022 ОН

Published by

**giz** Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

## Хэвлэсэн

Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

## Хаяг

Бонн, Эшборн хот, ХБНГУ  
Фредих-Элберт-Аллэ 32-36  
Д-53113 Бонн, ХБНГУ  
Утас +49 228 4460-0

Даг-Хаммарскуолд-Вег 1-5  
Д-65760 Эшборн, ХБНГУ  
Утас +49 6196 79-0  
Цахим хаяг [info@giz.de](mailto:info@giz.de)  
Цахим хуудас [www.giz.de](http://www.giz.de)

## Төслийн нэр

Ази дахь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих (SRECA)  
ТаЮуан Дипломат Байр  
14 Лиангмае Өмнөд Гудамж, Чаояанг Дүүрэг  
10600 Бээжин, БНХАУ  
Утас +86-10-8532-1857  
Цахим хаяг [sreca@giz.de](mailto:sreca@giz.de)  
Цахим хуудас [www.connecting-asia@giz.de / www.giz.de/en/worldwide/34101.html](http://www.connecting-asia@giz.de / www.giz.de/en/worldwide/34101.html)

## Зохиогчид/Боловсруулсан

Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Ганчимэг, Х.Бодьсайхан, Э.Тэмүүлэн  
"Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн" НҮТББ  
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан  
ХААИС-ийн ЭЗБС-ийн 202 тоот  
Утас + 976 99092644, + 976 88005829  
Цахим хаяг [info@inrae.mn](mailto:info@inrae.mn)  
Цахим хуудас [www.inrae.mn](http://www.inrae.mn)

## Хянасан

С. Золзаяа, GIZ SRECA  
Флориан Мисс, GIZ SRECA

## Зураг

GIZ

## Агуулгын хариуцлагаас татгалзах тухай

Энэхүү гарын авлагад зохиогчдын зүгээс илэрхийлсэн үзэл бодол болон саналд байгууллагын саналыг тусгаж, илэрхийлээгүй болно. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) нэрийн өмнөөс/даалгавраар GIZ нь хэрэгжүүлэгч агентлагийн хувьд гарын авлагын агуулгыг хариуцна.

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар .....	7
Хүснэгтийн жагсаалт .....	<b>8</b>
Зургийн жагсаалт .....	8
НЭГ. БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл .....	10
ХОЁР. БНХАУ-ын зах зээлд Монгол улсаас экспортлох боломжтой мах, махан бүтээгдэхүүн .....	19
2.1 Лаазалсан, савласан, нөөшилсөн үхрийн мах .....	21
2.2 Хиам зайдаснаас бусад бэлтгэж савласан, нөөшилсөн үхрийн махан бүтээгдэхүүн .....	22
2.3 Хонь ямааны шинэ, хөргөсөн мах .....	24
2.4 Хонь, ямаа, адууны хөлдөөсөн мах .....	26
2.5 Нохой, муурын хоол .....	27
2.6 Давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан үхрийн мах .....	29
2.7 Хөлдөөсөн хонь, ямааны гулууз, хагас гулууз .....	30
2.8 Хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мах, гэдэс дотор болон цус, эдгээр бүтээгдэхүүнд суурилсан хүнсний бэлдмэл .....	31
ГУРАВ. БНХАУ-ын зах зээлд мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломж, зохицуулалт .....	34
3.1 Худалдааны зохицуулалт .....	34
3.2 Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн хянан магадалгаа .....	37
3.3 БНХАУ-ын зах зээлийн зохицуулалт, нэвтрэх үйл явц .....	38
3.4 Экспортод гаргах бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошго .....	44
ДӨРӨВ. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц .....	47
4.1 Гэрчилгээ, зөвшөөрөл .....	47
4.2 Тээвэрлэлт .....	50
4.3 Гаальтай холбоотой процесс .....	50
ТАВ. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход анхаарах асуудал, зөвлөмж .....	55
ЗУРГАА. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай баримт бичиг .....	57
ДОЛОО. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход оролцогч байгууллагууд .....	58

7.1	Монгол Улс болон БНХАУ-ын талаас оролцогч ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД .....	58
7.2	Монгол Улс болон БНХАУ-ын талаас оролцогч ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД .....	60
7.3	Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газраас итгэмжлэгдсэн тээврийн компаниуд .....	60
7.4	БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн импортлогч томоохон компаниуд	61
	НАЙМ. Корона ВИРУСИЙН цар тахалтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт .....	61
8.1	ОЛОН УЛСАД ба БНХАУ-д .....	61
8.2	МОНГОЛ УЛСАД .....	65
8.3	Ковид-19 цар тахалтай холбоотой махны экспортын нөхцөл байдал .....	65

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
БТКУС	Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Систем
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ГҮС	Гарал Үүслийн Систем
ДГБ	Дэлхийн Гаалийн Байгууллага
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ММХ	Монголын Махны Холбоо
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
МЭГ	Мал Эмнэлгийн Гэрчилгээ
МЭЕГ	Мал Эмнэлгийн Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХТ	Олон Улсын Худалдааны Төв
СХЗГ	Стандарт, Хэмжил Зүйн Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ЧХШХЦЕГ	БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар
CNCA	Certification and Accreditation Administration of China
CNIPA	China National Intellectual Property Administration
DC	Documentary Collections
GACC	General Administration Customs of China
LC	Letter of Credit
NHCC	National Health Commission of China
SAC	Standardization Administration of China
SAMR	State Administration for Market Regulation

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Харилцан адилгүй температурт боловсруулсан мах махан бүтээгдэхүүний харьцуулалт	17
Хүснэгт 2	Сонгосон бүтээгдэхүүний ангилал, тодорхойлолт	19
Хүснэгт 3	ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс болон БНХАУ нэгдэн орсон байдал	34
Хүснэгт 4	Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандарт	34
Хүснэгт 5	Монгол Улсад махны экспортын талаар мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичиг	36
Хүснэгт 6	Махны үйлдвэрт мөрдөгдөж буй үндэсний стандарт, эрх зүйн баримт бичиг	36
Хүснэгт 7	Мах, махан бүтээгдэхүүнийг хүлээн авахад мөрдөгдөж буй стандарт	37
Хүснэгт 8	БНХАУ-ын хүнсний импортыг зохицуулах байгууллагууд	40

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1	Мах боловсруулах үйлдвэрлэлийн үнэ цэнийн сүлжээ	10
Зураг 2	БНХАУ-ын нийт мах үйлдвэрлэл (сая.тонн)	12
Зураг 3	БНХАУ-ын мах үйлдвэрлэлийн бүтэц 2020 ( % )	12
Зураг 4	БНХАУ-ын мах үйлдвэрлэл 2016-2020 (сая тонн)	13
Зураг 5	БНХАУ-ын боловсруулсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2013-2019( сая.тн )	13
Зураг 6	БНХАУ-ын нэг хүнд ногдох махны хэрэглээ (кг/хүн)	15
Зураг 7	БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)*	21
Зураг 8	БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)*	22
Зураг 9	БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)*	22
Зураг 10	БНХАУ-ын HS: 160250 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	23
Зураг 11	БНХАУ-ын HS:160250 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)	23
Зураг 12	БНХАУ-ын HS:160250 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)	24
Зураг 13	БНХАУ-ын HS:020422 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	24
Зураг 14	БНХАУ-ын HS:020422 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)	25
Зураг 15	БНХАУ-ын HS:020422 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)	25
Зураг 16	БНХАУ-ын HS:020690 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	26

Зураг 17	БНХАУ-ын HS:020690 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)	26
Зураг 18	БНХАУ-ын HS:020690 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)	27
Зураг 19	БНХАУ-ын HS:230910 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	27
Зураг 20	БНХАУ-ын HS:230910 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)	28
Зураг 21	БНХАУ-ын HS:230910 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)	28
Зураг 22	БНХАУ-ын HS:021020 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	29
Зураг 23	БНХАУ-ын HS:021020 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)	29
Зураг 24	БНХАУ-ын HS:021020 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)	30
Зураг 25	БНХАУ-ын HS:020441 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	30
Зураг 26	БНХАУ-ын HS:020441 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)	31
Зураг 27	БНХАУ-ын HS:020441 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын (ам.дол)	31
Зураг 28	БНХАУ-ын HS:160100 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	32
Зураг 29	БНХАУ-ын HS:160100 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)	32
Зураг 30	БНХАУ-ын HS:160100 кодтой бүтээгдэхүүний үнэ (ам.дол/кг)	33
Зураг 31	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад бүрдүүлэх материал	49
Зураг 32	Тээврийн дагалдах бичиг баримт	50
Зураг 33	Импортлогчийн бараа хүлээн авах үе шат	53

## НЭГ. БНХАУ-ЫН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

БНХАУ-ын мах боловсруулах үйлдвэрлэлийн үнэ цэнийн сүлжээг авч үзвэл сүлжээний эхний үе шат нь мал аж ахуй (гахай, шувуу гэх мэт) болон тэжээлийн үйлдвэрлэл, дунд үе шатанд нядалгаа, мах, махан бүтээгдэхүүний анхан, хагас болон гүн боловсруулалт хийх, эцсийн үе шатанд хүйтэн гинжин хэлхээ, логистик ба тээвэрлэлт, эцэст нь хэрэглэгчдэд хүргэх гэсэн үе шатуудаас бүрдэж байна (Зураг 1).

**Зураг 1.** Мах боловсруулах үйлдвэрлэлийн үнэ цэнийн сүлжээ.



**Эх сурвалж:** Хятадын Бизнес, Аж Үйлдвэрийн Судалгааны Хүрээлэн: <https://www.zhihu.com/org/>

### Гахайн махны үйлдвэрлэл:

Африкийн гахайн өвчин мөн шинэ корона вирусийн цар тахал гарсан нь гахайн аж ахуйд хүндрэл учруулж байна. 2020 он бол Мал аж ахуй, шувууны аж ахуйн хувьд хамгийн хүнд үе, хямрал, боломжууд зэрэгцсэн үе байв. Гахайн мах үйлдвэрлэлийн зах зээлд цар тахлын тархалтын сөрөг нөлөө хүндээр тусч байна. Тэжээлийн үйлдвэрлэл, тээвэрлэлт, гахайг нядлах, боловсруулах, амьд гахай, гахайн махыг бүс дамнуулан тээвэрлэх зэрэг гахайн махны үйлдвэрлэлийн сүлжээний бүх дамжлагуудад үйл ажиллагаа доголдож, зарим аж ахуй, бүс нутгуудыг тусгаарлах ажлыг янз бүрийн түвшинд явуулж байгаа нь гахайн аж ахуйд сөргөөр нөлөөлж байна. БНХАУ-ын Хөдөө аж ахуйн яамны мэдээлснээр 2019 онд нядалсан гахайн тоо толгой 544 сая болж өмнөх онтой харьцуулахад 21.6%-иар, гахайн махны үйлдвэрлэл 2016 онд 54.3 сая тонн байсан бол 2020 онд 38 сая тонн болж 16.3 сая тонн буюу 29.9%-иар тус тус буурсан байна.

### Шувууны мах үйлдвэрлэл:

БНХАУ бол шувууны аж ахуй эрхэлдэг томоохон үйлдвэрлэгч улс юм. Сүүлийн жилүүдэд шувууны махан бүтээгдэхүүний үнэ тасралтгүй нэмэгдэж, шувууны аж ахуйн үр ашиг сайжирч, шувууны аж ахуйн цар хүрээ өргөжин тэлсээр байна. Үндэсний Статистикийн газрын мэдээллээр 2019 онд тус улсын нийт нядалсан шувууны тоо толгой 14.6 тэрбумд хүрч өмнөх оноос 11.8%-аар өссөн байна. 2016 онд шувууны махны үйлдвэрлэлийн хэмжээ 18.8 сая тонн байсан бол 2020 онд 23.5 сая тонн болж 4.63 сая тонн буюу 24.5%-аар өссөн байна.

### Үхрийн мах үйлдвэрлэл:


БНХАУ 2016 онд үхрийн махны үйлдвэрлэлийн хэмжээ 6.2 сая тонн байсан бол 2020 онд 6.9 сая тонн болж 731 мянган тонноор буюу 11.8%-аар үхрийн махны үйлдвэрлэл өссөн байна. БНХАУ-д үхрийн махны үйлдвэрлэлийн хэмжээ жилд дунджаар 6 сая тонноос дээш байна. Шандун муж, ӨМӨЗО үхрийн махны үйлдвэрлэлээр тэргүүлж жилд дунджаар 600-750 мянган тонн орчим үхрийн мах үйлдвэрлэж байгаа бол Хэбэй, Хар мөрөн, Шин Жиан, Жилин, Юннань, Си Чуань, Хэнань, Лианонинг мужууд үхрийн махны үйлдвэрлэлээр тэргүүлж эхний 10 байрыг эзэлж байна

### Хонины мах үйлдвэрлэл:

БНХАУ-ын хонь, ямааны махны үйлдвэрлэлийн хэмжээ нь гахай, шувуу, үхрийн махны үйлдвэрлэлийн дараа эрэмбэлэгддэг. 2016 онд хонины махны үйлдвэрлэлийн хэмжээ 4.6 сая тонн байсан бол 2020 онд 4.9 сая тонн болж 340 мянган тонн буюу 7.4%-аар өссөн байна. БНХАУ-ын хонины аж ахуйн үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд харьцангуй эрчимжиж байгаа хэдий ч хонины махны импорт өндөр байсаар байна. Цаашид хонины аж ахуйн үйлдвэрлэл тогтвортой хөгжих хандлагатай байна.

БНХАУ-ын махны үйлдвэрлэлийн хэмжээ 2016 онд нийт 83.9 сая тонн байсан бол 2020 онд нийт 73.3 сая тонн болж 10.6 сая тонн буюу 12.6%-аар буурсан байна. Нийт махны үйлдвэрлэлийн хэмжээ буурсан нь гахайн махны үйлдвэрлэл их хэмжээгээр буурснаас шалтгаалжээ. БНХАУ-ын нийт махны үйлдвэрлэлийн хэмжээг гахайн, шувуу, үхэр, хонины махны үйлдвэрлэлийн нийлбэрээр нэгтгэн Зураг 2-т харууллаа.


**Зураг 2.** БНХАУ-ын нийт мах үйлдвэрлэл (сая.тонн)



**Эх сурвалж:** Хятадын Бизнес, Аж Үйлдвэрийн Судалгааны Хүрээлэн: <https://www.zhihu.com/org/>, Хятадын бизнесийн мэдээллийн сүлжээ: <https://www.askci.com/>

2020 оны байдлаар БНХАУ-ын нийт мах үйлдвэрлэлийн 84%-ийг гахайн мах, шувууны махны үйлдвэрлэл эзэлж байна. Монгол улсаас экспортлох боломжтой хонь, ямаа, үхрийн мах харьцангуй бага хувийг эзэлж байгаа мэт харагдаж байгаа боловч БНХАУ-ын зах зээлийн хэмжээтэй Монгол улсын мах үйлдвэрлэлийн чадавхыг харьцуулахад хангалттай хэмжээний зах зээлийн багтаамж бий (Зураг 3).


**Зураг 3.** БНХАУ-ын мах үйлдвэрлэлийн бүтэц 2020 (%)



**Эх сурвалж:** Хятадын Бизнес, Аж Үйлдвэрийн Судалгааны Хүрээлэн: <https://www.zhihu.com/org/>, Хятадын бизнесийн мэдээллийн сүлжээ: <https://www.askci.com/>

Махны үйлдвэрлэлийн сүүлийн таван жилийн мэдээллээс харахад 2020 онд 2016 оноос гахайн махны үйлдвэрлэл хамгийн их хэмжээгээр буюу 29.9%-аар буурсан харин бусад төрлийн мах болох шувууны махны үйлдвэрлэл 24.5%, үхрийн махны үйлдвэрлэл 11.8%, хонины махны үйлдвэрлэл 7.4%-аар тус тус өссөн байна (Зураг 4).

**Зураг 4.** БНХАУ-ын мах үйлдвэрлэл 2016-2020 (сая.тонн)




**Эх сурвалж:** Хятадын Бизнес, Аж Үйлдвэрийн Судалгааны Хүрээлэн: <https://www.zhihu.com/org/>, Хятадын бизнесийн мэдээллийн сүлжээ: <https://www.askci.com/>

<https://www.mordorintelligence.com/industry-reports/china-processed-meat-market>

### Мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл:

БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн цар хүрээ өргөжин тэлсээр байна. Мах боловсруулах үйлдвэрлэл хөгжиж байгаа хэдий ч үйлдвэрлэл, боловсруулалтын түвшин өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрч чадаагүй байна. Боловсруулалтын түвшнийг үл харгалзан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг авч үзвэл дараах байдалтай байна.

**Зураг 5.** БНХАУ-ын боловсруулсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2013-2019 (сая.тонн)



**Эх сурвалж:** Хятадын бизнесийн мэдээллийн сүлжээ: <https://www.askci.com/>

БНХАУ -ын махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 2018 онд 17.1 сая тонн байсан бол 2019 онд 15.8 сая тонн болж 1.3 сая тонноор буюу 7.7%-иар буурсан байна.

### Импорт:

БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын мэдээлснээр 2020 онд БНХАУ улс 9.9 сая тонн мах (дайвар бүтээгдэхүүнийг оролцуулан) импортолсон нь өмнөх оны мөн үеэс 60.4% -аар өссөн, импорт мөнгөн дүнгээр 30.7 тэрбум ам.долл буюу өмнөх оны мөн үеэс 59.6% -аар, үүнээс гахайн махны импорт 4.0 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 108.3% -аар, тахианы махны импорт 1.4 сая тонноор буюу өмнөх оны мөн үеэс 98.2% -аар, үхрийн махны импорт 2.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 27.6% -аар тус тус өссөн байна.

2020 онд БНХАУ-ын гахайн махны импортын хэмжээ 4.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 108.3% -аар өссөнөөр импортын хэмжээ мөнгөн дүнгээр 12.0 тэрбум ам.доллар хүрч, өмнөх оны мөн үеэс 157.5% -аар өсжээ. Нэг тонн гахайн махны импортын үнэ 2742 ам.долл байсан нь өмнөх оны мөн үеэс 23.64% -аар өссөн байна.

Гахайн махыг Испани, АНУ, Герман, Бразил, Канад, Дани зэрэг 20 орноос импортолдог бөгөөд Испани улс хамгийн их буюу 961.5 мянган тонн буюу нийт импортын 21.9% -ийг, АНУ 699.0 мянган тонн буюу 15.9% , Бразил 489.9 мянган тонн буюу 11% -ийг эзэлж байна.

2020 онд БНХАУ-ын тахианы махны импортын хэмжээ (бүхэл тахиа, тахианы нуруу, тахианы хөл, тахианы далавч орно) 1.4 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 98.3% -аар, импорт мөнгөн дүнгээрээ 3.3 тэрбум ам.долл буюу өмнөх оны мөн үеэс 74.7% -аар өссөн байна. Импортын дундаж үнэ 2291 ам.долл / тонн болж, өмнөх оны мөн үеэс 11.8%-аар үнэ нь буурчээ.

Тахианы махыг Бразил, АНУ, ОХУ, Тайланд зэрэг 12 орноос импортолдог бөгөөд Бразил улс дангаараа 637.6 мянган тонн буюу 44.5% -ийг эзэлж, дараа нь АНУ 391.1 мянган тонн буюу 27.3%, ОХУ 141.6 мянган тонн буюу 9.8%-ийг тус тус эзэлж байна.


2020 онд БНХАУ-ын үхрийн махны импортын хэмжээ 2.1 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 27.6% -аар өсжээ. Импорт мөнгөн дүнгээр 10.2 тэрбум ам.долл болж өмнөх оны мөн үеэс 23.7% -аар өссөн байна. Импортын дундаж үнэ 4805 ам.долл/тонн байсан нь өмнөх жилийн дунджаас 3.1% -аар буурсан үзүүлэлт юм. Үхрийн махны импортыг Бразил, Аргентин, Австрали, Уругвай, Шинэ Зеланд зэрэг 29 орноос хийдэг бөгөөд Бразилаас импортолсон хэмжээ 848.4 мянган тонн буюу 40.1%-ийг эзэлдэг бол Аргентин 482.6 мянган тонноор 22.8%, Австрали 253.3 мянган тонноор 11.9% -ийг тус тус бүрдүүлдэг байна.

2020 онд БНХАУ-ын хонины махны импорт 365.0 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 7% -аар буурчээ. Нийт махны импорт мөнгөн дүнгээр 1.7 тэрбум ам.долл болж өмнөх оны мөн үеэс 6.3% -аар буурсан бол харин импортлох дундаж үнэ 4779 ам.долл/тонн байсан нь 0.7% -аар өссөн үзүүлэлт. Импортын хонины махыг Шинэ Зеланд, Австрали, Уругвай зэрэг 7 улсаас импортолж байгаа бөгөөд үүнд Шинэ Зеландаас 200.6 мянган тонныг импортолж байгаа нь 55%, Австрали 152.2 мянган тонн буюу 41.7%, Уругвай 8.2 мянган тонн буюу 2.3%-ийг тус тус эзэлж байна.

### Махны хэрэглээ:

БНХАУ махны хэрэглээгээр хамгийн том хэрэглэгч орон гэж эрэмбэлэгддэг бөгөөд гахай, шувуу, үхэр, хонины мах хэрэглээний зонхилох хувийг бүрдүүлдэг. БНХАУ-ын зарим мужуудад гарсан Африкийн гахайн ханиад өвчинтэй холбоотойгоор олон тооны гахайг устгасны улмаас дотоодын гахайн махны нийлүүлэлт буурч, үнэ огцом өссөнөөс 2019, 2020 онуудад орлох бүтээгдэхүүн болох бусад төрлийн мах, үхэр, хонины махны эрэлт эрс нэмэгджээ.

Зураг 6. БНХАУ-ын нэг хүнд ногдох махны хэрэглээ (кг/хүн)



Эх сурвалж: Хятадын Бизнес, Аж Үйлдвэрийн Судалгааны Хүрээлэн: <https://www.zhihu.com/org/>, Хятадын бизнесийн мэдээллийн сүлжээ: <https://www.askci.com/>  
Зах зээлийн судалгаа: <https://www.marketresearch.com/IBISWorld-v2487/Meat-Processing-China-Research-14687249/>

Нэг хүнд оногдох жилийн дундаж гахайн махны хэрэглээ хамгийн өндөр буюу 28.9 кг/хүн, шувууны мах 16.2 кг/хүн байна. Үхрийн махны нэг хүнд ноогдох хэрэглээ 5.9 кг/хүн байгаа нь дэлхийн дунджаас бага байгаа бөгөөд энэ хэрэглээ цаашид өсөх хандлагатай байгаа юм. Харин хонины махны хэрэглээ 3.8 кг/хүн байна. Африкийн гахайн ханиад өвчин гарсантай



холбоотойгоор дотоодын гахайн махны хэрэглээ буурч импортын гахайн махны хэрэгцээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Хүн амын орлого, амьжиргааны түвшин тасралтгүй сайжирч, амьдралын хэмнэл хурдацтай өөрчлөгдөж байгаа учраас хэрэглэгчид чанартай, тохь тухтай, хялбар хэрэглээг илүүд үзэх хандлага, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл чухал болж байна. Иймээс өндөр чанартай, үнэ цэнэ шингэсэн, аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсээр байна.

Мах, махан бүтээгдэхүүний нэр томъёоны үндэсний стандарт (GB / T19480-2009) -ын дагуу мах, махан бүтээгдэхүүнийг Хятадын мах, махан бүтээгдэхүүн, барууны мах, махан бүтээгдэхүүн гэсэн хоёр ангилалд хуваадаг.

1. Хятад маягийн махан бүтээгдэхүүнд голчлон гахайн мах, хятад хиам, амталж хатаасан мах, чанасан махан бүтээгдэхүүн орно.
2. Барууны хэв маягийн махан бүтээгдэхүүн нь хиам, зайдас, утсан мах зэргийг багтаадаг.

БНХАУ-ын мах үйлдвэрлэлийн технологи, боловсруулалтын түвшин хангалттай түвшинд хүрээгүй байгаа бөгөөд боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хүрсэн түвшин нь хүмүүсийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаа юм. Тухайлбал, боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нийт мах үйлдвэрлэлийн 3.6% -ийг л эзэлж байгаа бөгөөд нэг хүнд ногдох жилийн дундаж нь 2кг-аас бага байгаа нь өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад хэт доогуур үзүүлэлт.

БНХАУ-ын хүн амын хооллох онцлог, мах боловсруулах технологийн хөгжил зэрэгтэй холбоотойгоор Хятад маягийн боловсруулсан махан бүтээгдэхүүн онцлог байдаг. Тэдний мах, махан бүтээгдэхүүний хэрэглээний бүтцэд халууны боловсруулалт хийгдсэн мах, махан бүтээгдэхүүн өнөөг хүртэл давамгайлсаар байна. Өндөр хөгжилтэй улс орнуудад бага температурт боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ зонхилох байр суурийг эзэлдэг бол БНХАУ-ын зах зээлд энэ төрлийн бүтээгдэхүүний эзлэх хувь бага байна. БНХАУ-ын боловсруулсан махны зах зээлд өндөр температурт халуун боловсруулалт хийгдсэн махан бүтээгдэхүүн 62%-63%, харин бага температурт халуун боловсруулалт хийгдсэн махан бүтээгдэхүүн 27%-28%-ийг эзэлж байна. Бага температурт мах махан бүтээгдэхүүнийг боловсруулах явцад уургийн агууламж хадгалагддаг бөгөөд мах нь шинэхэн, зөөлөн, зажлууртай, шаржигнуур, шүүслэг байж махны тэжээллэг чанар, өвөрмөц амтыг хамгийн боломжит дээд хэмжээнд хадгалж чаддаг.

Ингэж боловсруулсан махны чанар өндөр температурт боловсруулсан махан бүтээгдэхүүнийхээс хавьгүй өндөр байдаг гэж үздэг.

**Хүснэгт 1.** Харилцан адилгүй температурт боловсруулсан мах махан бүтээгдэхүүний харьцуулалт

Төрөл	Онцлог шинж чанар	Тэжээллэг, амт	Хадгалах хугацаа	Төлөөлөх бүтээгдэхүүн
Өндөр температурт махан бүтээгдэхүүн	Өндөр температурт боловсруулсан, 1150C-1210C хэмд боловсруулсан	Уураг, шим тэжээл их алдагдсан, амт муу	6-12 сар	Хиам, савласан бэлэн мөч гэх мэт
Бага температурт махан бүтээгдэхүүн	Бага температурт буюу буюу 00C-40C хэмд боловсруулж савласан, боловсруулалтын бүх процесс нь бага температурт хийгдсэн, бичил биетний үржлийг дарангуйлсан.	Уургийн агууламж их, тэжээллэг, амт сайтай	45 хоног хүртэл	Гал дээр дахин боловсруулалт хийх шаардлагатай бүтээгдэхүүнүүд

Хүн амын амьжиргааны түвшний дээшлэлт, эрүүл хооллолтын хэв маяг дэлгэрч байгаатай холбоотойгоор мах, махан бүтээгдэхүүний зах зээлд бага температурт боловсруулсан бүтээгдэхүүний хэрэгцээ цаашид өсөх хандлага ажиглагдаж байгаа ба улмаар махны хэрэглээнд гарч буй өөрчлөлтийг дараах дөрвөн чиглэлд хувааж болохоор байна. Үүнд:

1. Гахайн махны хэрэглээ хэлбэлзэж, үхэр, хонины махны хэрэглээ нэмэгдэх.
2. Шинэ, сэврээсэн махны хэрэглээ хурдацтай нэмэгдэх.
3. Дунд болон өндөр температурт боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хэрэглээнээс бага температурт боловсруулсан бүтээгдэхүүний хэрэглээ рүү шилжих.
4. Тохь тухтай, түргэн шуурхай үйлчилгээг эрхэмлэх, хоолны үйлчилгээ авах хэрэглээ өсөх.

Дунд болон өндөр температурт боловсруулж бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний хэрэглээтэй харьцуулахад шинэ мах, бага температурт боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн нь эрүүл хэрэглээний чиг хандлагад илүүтэй нийцэж байгаа бөгөөд ирээдүйд ийм төрлийн махны хэрэглээний өсөлт нь орлого өндөртэй хэрэглэгчид хурдацтай нэмэгдэж байгаа, иргэдийн дунд эрүүл хүнсний хэрэглээний ойлголт, хэрэглээний шинэчлэл эергээр өөрчлөгдөж байгаагаас улбаалан тасралтгүй нэмэгдэх хандлагатай. Мөн өөх

тос багатай, давс багатай, эслэг агуулсан, төмөр, цайр, кальцийн баяжуулагч агуулсан мах, махан бүтээгдэхүүнүүдийн эрэлт цаашид өсөх хандлагатай байна.

Бизнесийн шинэ загвар, махны шинэ хэрэглээ үүсэж бий болж байгаа ба гол хэрэглэгчид нь шинэ үеийнхэн буюу 80,90-ээд онд төрсөн залуус бөгөөд БНХАУ-д энэ насны бүлгийн 450 сая хүн амьдардаг. Мөн томоохон хотын завгүй амьдралын хэв маягтай хэрэглэгчид дээрх хэрэглэгчдийн бүлэгт нэмэгдэнэ. Тэд нийгмийн хамгийн идэвхтэй хэсэгт тооцогдох ба мөн худалдан авах чадвар хамгийн өндөртэй. Хүмүүс гэртээ хоол хийх нь багасаж амралт, зугаалга, чөлөөт цагаараа идэх хоол хүнсний хэрэглээ хурдацтай өсөж байна. Цахим хоол захиалгын үйлчилгээ, амт, хурд, тав тухтай байдал, бэлэн хоол, халуун тогоо, хөнгөн хоол, түргэн хоол, өглөөний хоол гэх мэт хоолны олон чиглэлүүдийн хөгжил дэвшилтэй уялдан тэдгээрт хэрэглэгдэх мах, махан бүтээгдэхүүн нь мах боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь ирээдүйн шинэ чиглэл болж байна.

## ХОЁР. БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД МОНГОЛ УЛСААС ЭКСПОРТЛОХ БОЛОМЖТОЙ МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

Бид Монгол улс ба БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн мэдээлэлд тулгуурлан зах зээлийн шинжилгээний Портерын загвар, олон улсын худалдаан дахь тухайн бүтээгдэхүүний давуу талыг тодорхойлох RCA индексээр Монгол улсаас БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх боломжтой бүтээгдэхүүнийг эрэмбийг гаргасан болно. Судалгаагаар доорх ангиллын бүтээгдэхүүнүүдийг БНХАУ-ын зах зээлд нэн түрүүнд нийлүүлэх боломж, давуу талтай болохыг тодорхойллоо.

**Хүснэгт 2.** Сонгосон бүтээгдэхүүний ангилал, тодорхойлолт

Эрэмбэ <sup>2</sup>	HS код	Бүтээгдэхүүний нэр	Зүйлийн бүтэц	Хяналт шинжилгээний бөйгөл	Хяналт шалгалт, хорио цээрийн ангилал	НӨАТ (%)	Импортын тариф (%)
2	160290	1602909010 1602909090	Бэлтгэсэн буюу хадгалсан мах, дотор эрхтэн, цус (шувууны мах, гахайн мах, үхрийн махнаас бусад ...)	1602: Бусад аргаар бэлтгэсэн буюу хадгалсан мах, хоол боловсруулах эрхтэн, амьтны цус. 16029: Амьтны цусыг багтаасан бусад хоол хүнс:	AB	PRQS	13% 5%
3	160250	1602509090	Хатаасан үхрийн мах (Карритай)		AB	PRQS	13% 5%
4	020442	0204420000	Хөлдөөсөн хонь, ямааны ястай мах		7AB	PRQS	9% 12%
5	020422	0204220000	Хонины шинэ буюу хөргөсөн зүсмэл, ястай (гулууз, хагас кармаас бусад)	0204: Шинэ, хүйтэн, хөлдөөсөн хонь, ямааны мах. 02042: Бусад шинэ эсвэл хүйтэн хонины мах:	7AB	PRQS	9% 15%

<sup>2</sup> Энэ баганад бүтээгдэхүүнийг RCA индекс, Портерийн таван хүчний загварыг ашиглан Монгол улсаас БНХАУ-д экспортлох боломжтой бүтээгдэхүүний "эрэмбийг" харуулж байгаа бөгөөд нэгдүгээр эрэмбэд адууны мах эрэмбэлэгдсэн бөгөөд адууны махны экспортоор тусгайлан гарын авлага боловсруулагдсан тул энэхүү жагсаалтад оруулаагүй болно.

6	<020690	0206900010	Хонь, ямаа, адууны хөлдөөсөн мах		7AB	PRQS	9%	18%
7	<230910	02309109000	Гэрийн тэжээвэр амьтдын хоол	2309: Бэлтгэсэн малын тэжээл. 23091: Жижиглэнгийн савласан нохой, муурны хоол:	AB	PR	9%	15%
8	<021020	0210200010	Давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан үхрийн мах	0210: Мах, хүнсний ногооны салат, хатаасан, утсан эсвэл давсалсан мах. 02102000: үхрийн мах	ABFE	PRQS	9%	25%
9	<020441	0204410000	Хөлдөөсөн хонины гулууз, хагас гулууз	0204: Шинэ, хүйтэн, хөлдөөсөн хонь, ямааны мах. 02044: Бусад хөлдөөсөн хонины мах:	7AB	PRQS	9%	23%
10	<160100	1601002090 1601001090 1601003010	Хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мах, гэдэс дотрын болон цус; эдгээр бүтээгдэхүүнд суурилсан хүнсний бэлдмэл	1601: Цусан хиам 16010020: Бусад хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн	AB	PRQS	13%	5%

**Тэмдэглэл:** Цэнхэр өнгөөр нөөшилсөн мах, улаан өнгөөр хөлдөөсөн махны кодыг тэмдэглэв.

**Эх сурвалж:** Судлаачдын тооцоолол болон <https://map.cn-hscode.com/>

Хяналт шинжилгээний байдал баганын тэмдэглэгээний тайлбар:

A – Ачаа тээврийг нэвтрүүлэх хуудас

B - Гадагшаа гарсан барааны гаалийн бүрдүүлэлтийн маягт

F - Ховордсон ан амьтдыг импортлох зөвшөөрлийн гэрчилгээ

E - Ховордсон ан амьтан экспортлох зөвшөөрлийн гэрчилгээ

7 - Автомат импортын лиценз

Хяналт шалгалт, хорио цээрийн ангиллын тайлбар:

P - Орох амьтан, ургамал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хорио цээр

R - Импортын хүнсний эрүүл ахуйн хяналт, шалгалт

Q - Гадагшаа гарсан амьтан, ургамал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хорио цээрийн дэглэм

S - Экспортлох хүнсний эрүүл ахуйн хяналт, шалгалт

Хүснэгт 2-д сонгогдсон бүтээгдэхүүнийг Монгол улсаас үйлдвэрлэн нийлүүлж байгаа эсэх болон нийлүүлэх боломжтой талаар экспортын зах зээлд оролцогч талуудтай хийсэн ярилцлагаар баталгаажуулсан болно. Дараагийн дэд хэсгүүдэд сонгосон бүтээгдэхүүн тус бүрээр товч мэдээлэл орууллаа.


### 2.1. Лаазалсан, савласан, нөөшилсөн үхрийн мах

1602: Бусад аргаар бэлтгэсэн буюу хадгалсан мах, хоол боловсруулах эрхтэн, амьтны цус;

16029: Амьтны цусыг багтаасан бусад хоол хүнс; 1602901090: Савласан үхрийн мах

Лаазалсан, савласан, нөөшилсөн бүтээгдэхүүнийг БНХАУ 2020 онд нийт 15.9 мянган тонныг импортлосон бөгөөд энэхүү бүтээгдэхүүнийг 100% Монгол улсаас импортлосон байна. Сүүлийн жилүүдэд энэ ангиллын бүтээгдэхүүний өсөлт өндөр байгаа нь доорх графикаас харагдаж байна.


**Зураг 7.** БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)\*



**Эх сурвалж:** <https://www.trademap.org/8> (төлбөртэй мэдээлэл)

Харин БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний экспорт жилээс жилд буурч байгаа бөгөөд 2020 онд нийт 2277 тонн бүтээгдэхүүн экспортолсон байна. БНХАУ-аас АНУ, Япон, Мексик зэрэг улсууд импорт хийжээ.

**Зураг 8.** БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)\*



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

Импортын үнэ буюу Монгол улсаас HS:160290 кодтой бүтээгдэхүүн худалдан авсан дундаж үнэ 2020 онд 2.35 ам.дол/кг байсан бол БНХАУ-аас бусад оронд экспорт хийж байгаа үнэ 5.30/кг ам.дол байжээ.

**Зураг 9.** БНХАУ-ын HS:160290 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)\*




Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

HS:160290 бүтээгдэхүүнийг зөвхөн Монгол улсаас импортолж байгаа учраас энэ бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар өндөр байна.

## 2.2. Хиамаас бусад бэлтгэж савласан, нөөжилсөн үхрийн махан бүтээгдэхүүн

HS:160250-д бэлтгэж савласан, нөөжилсөн үхрийн махан бүтээгдэхүүнийг оруулж байна. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын энэ бүтээгдэхүүний импорт өсөж байгаа бөгөөд 2020 онд 4342 тонныг Монгол улсаас импортолсон байна.


**Зураг 10.** БНХАУ-ын HS:160250 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

БНХАУ 2020 онд HS:160250 бүтээгдэхүүнийг 9008 тонныг Хонконг, Япон, Бурунди, Малайз зэрэг улсуудад экспортолсон байна.

**Зураг 11.** БНХАУ-ын HS:160250 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

Монгол улсаас импортолж байгаа бүтээгдэхүүнийг 2.97 ам.дол-оор/кг авч байгаа бол экспортын үнэ 6.30 ам.дол/кг байна. Эндээс экспорт, импортын үнийн зөрүү 3.33 ам.дол/кг буюу Монголоос авч байгаа үнэ БНХАУ-ын энэ кодтой бүтээгдэхүүний экспортын үнээс 2.12 дахин бага байна.

**Зураг 12.** БНХАУ-ын HS:160250 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)




Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

### 2.3. Хонь ямааны шинэ, хөргөсөн мах

HS:020422 нь хонь, ямааны шинэ, хөргөсөн мах бөгөөд БНХАУ Шинэ Зеланд, Австрали улсуудаас голлон импортолж байна. 2020 онд нийт 302 тонн бүтээгдэхүүн импортолсныг 100% Шинэ Зеландаас авсан бөгөөд 2020 онд Австралиас энэ бүтээгдэхүүнийг импортлоогүй байна.


**Зураг 13.** БНХАУ-ын HS:020422 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

2017 онд хонь ямааны 2 тонн, 2018 онд 1 тонн бүтээгдэхүүн экспортолсон бол 2019, 2020 онуудад экспорт хийгээгүй байна.

**Зураг 14.** БНХАУ-ын HS:020422 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

2020 онд импортын үнэ 8.19 ам.дол/кг байгаа нь манай улсын хонь ямааны махны хувьд харьцангуй өндөр үнэ болох учраас HS:020422 ангиллаар БНХАУ-ын зах зээлд хонь, ямааны мах экспортлох нь эдийн засгийн өгөөжтэй байх боломжтой юм.

**Зураг 15.** БНХАУ-ын HS:020422 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)




Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

## 2.4. Хонь, ямаа, адууны хөлдөөсөн мах

HS:020690 нь хонь, ямаа, адуу, илжиг, луусны хөлдөөсөн мах юм. Монгол улсын хувьд энэ бүтээгдэхүүний ангилалд хонь, ямаа, адууны хөлдөөсөн мах нийлүүлэх боломжтой. 2020 онд БНХАУ 5155 тонн бүтээгдэхүүн импортлосон бөгөөд Шинэ Зеланд, Австрали, Уругвай улсуудаас импортлосон байна. Хамгийн том импортлогч улс нь Шинэ Зеланд бөгөөд 2020 онд тус улсаас 3333 тонн бүтээгдэхүүн импортлосон байна.


**Зураг 16.** БНХАУ-ын HS:020690 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

БНХАУ 2020 онд HS:020690 кодтой бүтээгдэхүүн 104 тонныг АНЭУ, Иордан, Кувейт, Япон зэрэг улсуудад экспортолсон байна.

**Зураг 17.** БНХАУ-ын HS:020690 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

HS:020690 кодтой бүтээгдэхүүний экспортын үнэ 2020 онд 3.90 ам.дол, импортын үнэ 4.90 ам.дол байна. Уг бүтээгдэхүүний экспортын үнэ хамгийн өндөр байсан үе нь 2018 он буюу нэг кг бүтээгдэхүүнийг 19.25 ам.дол-оор экспортолсон байна.

**Зураг 18.** БНХАУ-ын HS:020690 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)




Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

## 2.5. Нохой, муурын хоол

HS:230910 нь нохой, муурын хоол ангиллын бүтээгдэхүүн бөгөөд БНХАУ нь Канад, АНУ, Тайланд, Шинэ Зеланд зэрэг маш олон орноос импортлож байна. 2020 онд нийт 106635 тонн бүтээгдэхүүн импортлосон байна. Үүний 50 орчим хувийг Канад улсаас, мөн Европын орнуудаас импортложээ.


**Зураг 19.** БНХАУ-ын HS:230910 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

БНХАУ-ын HS:230910 бүтээгдэхүүний экспорт 2020 онд 198.5 мян.тонн байсан ба жилээс жилд өсөж байгаа дүр зураг харагдаж байна. Энэ төрлийн бүтээгдэхүүнийг БНХАУ нийт 80 гаруй улс орон руу экспортолдог байна.

**Зураг 20.** БНХАУ-ын HS:230910 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

HS:230910 бүтээгдэхүүний импортын үнэ 5.83 ам.дол/кг, экспортын үнэ 4.96 ам.дол/кг байна. Монгол улсын хувьд малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, гэдэс, дотрыг ашиглан нохой муурын хоол үйлдвэрлэж БНХАУ-ын зах зээлд экспортолж боломж байна.

**Зураг 21.** БНХАУ-ын HS:230910 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)




Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

## 2.6. Давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан үхрийн мах

HS:021020 нь давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан үхрийн мах, амьтны мах гэсэн ангиллын бүтээгдэхүүн юм. Энэ төрлийн хатаасан үхрийн мах, утсан мах, борц, жерки зэрэг бүтээгдэхүүн БНХАУ-ын зах зээлд өргөн хэрэглэгдэж байна. HS:021020 ангиллаар БНХАУ 2016-2018 он хүртэл Монгол улсаас тодорхой хэмжээний бүтээгдэхүүн импортолж байсан боловч 2019, 2020 онд импортлоогүй байна. 2018 онд энэ ангиллаар 19 тонн бүтээгдэхүүн Монгол улсаас импортолжээ.


**Зураг 22.** БНХАУ-ын HS:021020 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

HS:021020 ангиллаар БНХАУ-аас гаргаж байгаа экспорт маш бага байна. 2016 онд 15 тонн бүтээгдэхүүн экспортолсон бол 2020 онд 1 тонн бүтээгдэхүүн экспортолсон байна.


**Зураг 23.** БНХАУ-ын HS:021020 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

БНХАУ HS:021020 ангиллын бүтээгдэхүүнийг Монгол улсаас 5.11 ам.дол/кг-оор авч байсан бол 2017 онд 13 ам.дол/кг, 2019 онд 9 ам.дол/кг, 2020 онд 21 ам.дол/кг-оор экспортолсон байна.

**Зураг 24.** БНХАУ-ын HS:021020 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол/кг)




Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

### 2.7. Хөлдөөсөн хонь, ямааны гулууз, хагас гулууз

HS:020441 нь хөлдөөсөн хонь ямааны гулууз, хагас гулууз ангиллын бүтээгдэхүүн юм. БНХАУ сүүлийн жилүүдэд энэ ангиллын бүтээгдэхүүнийг Шинэ Зеланд, Австрали, Уругвай, Аргентин, Чили, Монгол зэрэг улсуудаас импортолсон бөгөөд 2020 онд 23.1 мян.тонн бүтээгдэхүүн импортолсны 21.9 тонн буюу 94.7%-ийг зөвхөн Шинэ Зеланд улсаас импортолсон байна. Харин Монгол улсаас 2016 онд 48 тонн бүтээгдэхүүн импортлоод түүнээс хойш импортлоогүй байна.


**Зураг 25.** БНХАУ-ын HS:020441 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

БНХАУ HS:020441 ангиллын бүтээгдэхүүнийг 2016 онд 85 тонн, 2019 онд 5 тонныг экспортолсон байна. 2020 онд энэ ангиллаар бүтээгдэхүүн экспортлоогүй байна.


**Зураг 26.** БНХАУ-ын HS:020441 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

HS:020441 ангиллын бүтээгдэхүүний импортын үнэ 2020 онд 4.8 ам.дол/кг байсан бол, 2016 онд Монгол улсаас 1.7 ам.дол/кг -оор авч байсан байна. Тухайн үед импортын дундаж үнэ 2.7 ам.дол/кг байжээ. Харин экспортын үнэ 2016 онд 4.5 ам.дол/кг, 2019 онд 9.8 ам.дол/кг тус тус буюу үнэ нилээд өсөлттэй байжээ.

**Зураг 27.** БНХАУ-ын HS:020441 кодтой бүтээгдэхүүний экспорт, импортын үнэ (ам.дол)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)


### 2.8. Хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мах, гэдэс дотор болон цус, эдгээр бүтээгдэхүүнд суурилсан хүнсний бэлдмэл

HS:160100 нь Хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мах, гэдэс дотор болон цус, эдгээр бүтээгдэхүүнд суурилсан хүнсний бэлдмэл гэсэн ангиллын



бүтээгдэхүүнүүд бөгөөд Дани, Франц, Итали, Герман, Япон, Солонгос зэрэг 10 гаруй орноос БНХАУ энэ ангиллаар бүтээгдэхүүн импортолж байгаа бөгөөд Монгол улсаас ч тодорхой хэмжээгээр импорт хийж байна. 2020 онд нийт 525 тонн бүтээгдэхүүн импортолсны 475 тонныг буюу 90.4%-ийг зөвхөн Дани улсаас импортолсон байна. Монгол улсаас 2016 онд 3 тонн, 2017 онд 6 тонн, 2018 онд 26 тонн, 2019 онд 2 тонн бүтээгдэхүүн импортолж 2020 онд импорт хийгээгүй байна.


**Зураг 28.** БНХАУ-ын HS:160100 кодтой бүтээгдэхүүний импорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

HS:160100 ангиллын бүтээгдэхүүнийг БНХАУ 2020 онд 24.6 мян.тонныг дэлхийн нийт 35 улс руу экспортолжээ.

**Зураг 29.** БНХАУ-ын HS:160100 кодтой бүтээгдэхүүний экспорт (тонн)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

2016-2019 онуудад импортын үнэ 3.7 - 6 ам.дол байсан бол 2020 онд 7.6 ам.дол болж өссөн байна. Харин Монгол улсын хувьд ангиллаар нийлүүлж байгаа бүтээгдэхүүний үнэ сүүлийн жилүүдэд буурч байгаа нь бүтээгдэхүүний амтыг БНХАУ-ын хэрэглэгчдийн таашаалд нийцүүлж гаргаж чадахгүй байгаатай холбоотой байж болохыг манай үйлдвэрлэгчид анхаарах хэрэгтэй юм.

**Зураг 30.** БНХАУ-ын HS:160100 кодтой бүтээгдэхүүний үнэ (ам.дол/кг)



Эх сурвалж: <https://www.trademap.org/>, (төлбөртэй мэдээлэл)

## ГУРАВ. БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БОЛОМЖ, ЗОХИЦУУЛАЛТ

### 3.1 Худалдааны зохицуулалт

Монгол Улс 1991 онд Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ), 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын гишүүнээр элсэн орсноор эдгээр байгууллагын чиглэл, зарчмыг үндэсний хууль тогтоомжид уялдуулах, худалдааг хөнгөвчлөх талаарх олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

ДГБ болон ДХБ-аас гаргасан зарим бодлогын баримт бичигт нэгдэн орсон огноог дараах хүснэгтэд харьцуулан үзүүлэв.

**Хүснэгт 3.** ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс болон БНХАУ нэгдэн орсон байдал\*

№	Баримт бичгийн нэр	Монгол Улс	БНХАУ
1	ДГБ-ын Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (ДГБ байгуулах тухай Конвенц)	1991	1983
2	ДГБ-ын Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенц	1993	1993
3	ДГБ-ын Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц	2006	2001
4	ДГБ-ын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах хөнгөвчлөх багц стандарт	2005	2005
5	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (ДХБ-ын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр)	1997	2011
6	1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (ДХБ-ын Үнэлгээний Хэлэлцээр)	1997	2011
7	ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр	2016	2015

Тайлбар: \*гэрээ хүчин төгөлдөр болсон огноо  
Эх сурвалж: Д.Цэндсүрэн (Ph.D), Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, гаалийн үйл ажиллагааг уялдуулж, гадаад худалдааг хөнгөвчлөх боломж, 2019

Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандартуудыг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 4.** Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандарт

№	Баримт бичгийн нэр	Индекс, код	Монголын үндэсний стандартаар батлагдсан байдал
1	Махны эрүүл ахуйн дадлын дүрэм	CAC/RCP 58; 2005	<b>MNS CAC RCP 58:2013</b>
2	Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	ISO/MNS 22000	<b>MNS ISO/IEC 22000:2007</b>

3	Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим	CAC/MNS 1- 2003	<b>MNS CAC/ RCP 1 :2003</b>
4	Хүнсний импорт, экспортын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх, үнэлэх болон итгэмжлэх ерөнхий зарчим	CAC/GL 26- 1997	<b>MNS CAC/ GL 26- 2006</b>
5	Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт	CAC/MNS 193:2007	<b>MNS CAC 193:2007</b>
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	CAC/MNS/ MRL 2:2009	<b>MNS CAC MRL 2:2009</b>
7	Хүнс, малын тэжээлийн гарал үүсэл – ерөнхий 7 зарчим ба төлөвлөх, хэрэгжүүлэх тогтолцоонд тавих үндсэн шаардлага	ISO 22005	
8	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 1. Хүнсний үйлдвэр	ISO/TS 22002- 1:2009	
9	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 2. Хүнсний хангамж	SO/TS 22002- 2:2013	
10	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 3. Фермерийн аж ахуй	ISO/TS 22002- 3:2011	
11	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 4. Хүнсний савлагаа	ISO/TS 22002- 4:2013	
12	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 5. Тээвэрлэлт, хадгалалт	ISO/NP TS 22002-5:	
13	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 6. Малыг тэжээлийн ба малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл	ISO/TS 22002- 6:2016	

Эх сурвалж: МУ-ын СХЗГ

Монгол улсын Засгийн газраас мах, махан бүтээгдэхүүний экспортын талаар баримталж буй бодлого, зохицуулалтын тоймыг хүснэгт 5, 6, 7-д харууллаа.

**Хүснэгт 5.** Монгол Улсад махны экспортын талаар мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичиг

Хууль, эрхзүйн актууд	Төрийн бодлого, хөтөлбөр	Гэрээ, протокол	Дүрэм, журам
"Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай" хууль (2002.11.28)	"Монгол мал" үндэсний хөтөлбөр (2010 оны УИХ-ын 23-р тогтоол)  "Мах" хөтөлбөр (2015 оны УИХ-ын 41-р тогтоол) <i>2.2 дахь заалт</i>	Хүнсний аюулгүй байдлын экспорт-импортын хамтын ажиллагааны хэлэлцээр, 2009 он  Монгол Улсаас БНХАУ-д Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох үеийн хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл (2011.10.27)	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам ((МУ-ын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоол)  Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам (МУ-ын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоол)
"Хүнсний тухай" хууль (2012.12.20) <i>6.7 дахь зүйл заалт 18.1 дэх зүйл заалт</i>	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2015 оны УИХ-ын 104 дүгээр тогтоол)	Хил, гаалийн эрүүл ахуй, хорио цээрийн чиглэлд хамтран ажиллах Монгол улс, БНХАУ хоорондын хамтын ажиллагааны гэрээ, 2016	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам (МУ-ын Засгийн Газрын 2019 оны 329 дүгээр тогтоол)
"Хүнсний аюулгүй байдлын тухай" хууль (2012.12.20)	Мах, сүүний анхдугаар аян (Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоол)	Монгол Улсын МХЕГ болон БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн махны хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай протокол (2016.08.29)	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох, импортлох нэр, төрөл тоо, хэмжээг тогтоох тухай ХХААХУ-ны Сайдын тушаал
"Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хууль (2017.12.08)	"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоол  "Монгол Экспорт" хөтөлбөр (2018 оны МУ-ын Засгийн Газрын 278-р тогтоол)		Гэрчилгээ, мэдэгдэл олгох бичиг баримтыг хүлээн авах, хариу өгөх журам (МХЕГ даргын 2019 оны 05 сарын 27 А/81 тушаал)

**Хүснэгт 6.** Махны үйлдвэрт мөрдөгдөж буй үндэсний стандарт, эрх зүйн баримт бичиг

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Код, индекс
1	Хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зөвлөмж	<b>МХЕГ-ын даргын 2014 оны 156-р тушаал</b>
2	Мал төхөөрөх үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн тогтолцоо (НАССР)-ны загвар стандарт	<b>MNS 5998:2009</b>

3	Мах, махан бүтээгдэхүүн. "Үхрийн хэсэглэж ангилсан мах" техникийн шаардлага	<b>MNS 2456:2009</b>
4	Чанаж боловсруулсан мах, Техникийн ерөнхий шаардлага	<b>MNS 6790:2019</b>
5	Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	<b>MNS 4504:2008</b>
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	<b>MNS 5868:2008</b>
7	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах журам	<b>ЗГ-ын 2013 оны 172-р тогтоол</b>
8	Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ	<b>MNS 6308:2012</b>
9	Эм, био-бэлдмэлийн үлдэгдэл, мг/кг	<b>MNS CAC MRL 2:2017</b>

**Эх сурвалж:** МУ-ын СХЗГ

**Хүснэгт 7.** Мах, махан бүтээгдэхүүнийг хүлээн авахад мөрдөгдөж буй стандарт

1	Мах, махан бүтээгдэхүүнийг шалгаж хүлээн авах ба сорьц авах, мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгөх журам	<b>MNS 2551:89</b>
2	Микробиологи, мах, махан бүтээгдэхүүн. Дээж авах ба шинжилгээний сорьц бэлдэх.	<b>MNS ISO 3100-1:2000</b>
3	Мах, махан бүтээгдэхүүн. Махны шинэлэг байдлыг тодорхойлох шинжилгээний арга	<b>MNS 1161:2002</b>
4	Мах, махан бүтээгдэхүүн. Маханд хийх шинжилгээний арга ба мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний зарчим	<b>MNS 4080:88</b>
5	Микробиологи. Салмонелл илрүүлэх ерөнхий заавар	<b>MNS ISO 6579:99</b>
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэлийн үлдэгдлийн агууламжийг тодорхойлох өрсөлдөөнт иммуноферментийн арга	<b>MNS 6569:2016</b>

Дээрх стандарт, дүрмүүдийн дэлгэрэнгүйг Стандарт, хэмжилзүйн газрын лавлагаанаас болон <http://estandard.gov.mn/> цахим хуудсаас авч болно.

### 3.2 Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн хянан магадалгаа

Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд, холбогдох стандарт шаардлагуудыг хангасан байх ёстой бөгөөд МЭЕГ болон МХЕГ-аас дараах шалгах хуудаснуудын хүрээнд хяналт, шалгалт хийнэ.

1. Мах эхлэн боловсруулах үйлдвэрийг шалгах хяналтын хуудас
2. Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас
3. Махны хадгалалтын нөхцөлийг шалгах хяналтын хуудас
4. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас

5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас
6. Махны үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас (<https://www.mongolchamber.mn/p/41>)

### 3.3 БНХАУ-ын зах зээлийн зохицуулалт, нэвтрэх үйл явц

#### Зах зээлийн ерөнхий зохицуулалтууд:

БНХАУ-д мах боловсруулах үйлдвэрүүдэд дараах стандартын шаардлагууд тавигдаж байна.

- Hazard Analysis and Critical Control Point (HACCP) System - General Requirements for Food Processing Plant, National Standard of the PRC, GB/T 27341-2009
- National Food Safety Standard Hygienic Specification for Livestock and Poultry Slaughtering and Processing , National Standard of the PRC, GB 12694-2016
- General Rules for the Labelling of Prepackaged Foods, National Standard of the PRC, GB 7718 2011
- National Food Safety Standard Hygiene Practices for Food Operation Processes, GB31621-2014
- National Food Safety Standards, Hygiene Specifications for Meat and Meat Product Management, GB 20799-2016

Дээрх стандартууд болон холбогдох стандартуудыг БНХАУ-ын Стандартын Удирдлагын Газрын цахим хуудас (<http://www.sac.gov.cn/>) - аас авах боломжтой.

Экспортлогчид бүтээгдэхүүнийг экспортлохоосоо өмнө зах зээлд нэвтрэх боломжийг хангах ёстой. Экспортын хүнсний бүтээгдэхүүн Монгол Улс, БНХАУ-ын био аюулгүй байдал, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журмыг дагаж мөрдөх мөн түүнчлэн шошго, сав баглаа боодлын шаардлагад нийцсэн байх нь чухал ач холбогдолтой юм.

БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу экспортолсон мах, махан бүтээгдэхүүнтэй холбоотой бүх хариуцлагыг экспортлогч тал хүлээнэ. БНХАУ импортлохоос татгалзаж буй бүтээгдэхүүний ихэнх хувийг био аюулгүй байдлын шаардлага, бүтээгдэхүүний найрлага, сав баглаа боодол, хаяг шошгын стандарт хангаагүй зэрэг зөрчлүүдтэй холбоотой байна.

#### БНХАУ-ын холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг:

Одоогийн байдлаар БНХАУ-ын хүнсний экспорт, импортын аюулгүй байдлыг зохицуулдаг 30 гаруй хууль, дүрэм, журам үйлчилж байна. Эдгээрийн үндсэн суурь, чухал хууль нь БНХАУ-ын “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль” юм. Энэхүү хуульд хүнсний үйлдвэрлэл, хангамжийн сүлжээ, түгээх, борлуулах, эргүүлэн татах үйл явц дахь алхам бүрийг хянах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөн хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага, зохицуулалтууд илүү чухалчлан тусгагдсан байна. Тус хуульд үндэсний, орон нутгийн зохицуулах байгууллагуудад илүү их эрх мэдэл олгож, зөрчилд хатуу шийтгэл оноож, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлоход чиглэсэн тодорхой заалтууд орсон байна.

- “Хүнсний аюулгүй байдлын тухай хууль” ([http://www.gov.cn/zhengce/2015-04/25/content\\_2853643.htm](http://www.gov.cn/zhengce/2015-04/25/content_2853643.htm))
- “Импорт, экспортын бараа бүтээгдэхүүний хяналт шалгалтын тухай хууль”, түүнийг хэрэгжүүлэх журам ([http://www.gov.cn/gongbao/content/2017/content\\_5219176.htm](http://www.gov.cn/gongbao/content/2017/content_5219176.htm))
- БНХАУ-ын импорт, экспортын барааны хяналтын тухай хууль 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, (<http://www.customs.gov.cn/customs/302249/302266/302267/2369445/index.html>)
- “БНХАУ-ын амьтан, ургамлын хорио цээрийн тухай хууль” түүнийг хэрэгжүүлэх журам ([http://www.npc.gov.cn/wxzl/gongbao/2000-12/05/content\\_5004560.htm](http://www.npc.gov.cn/wxzl/gongbao/2000-12/05/content_5004560.htm))
- “БНХАУ-ын хилийн эрүүл мэнд, хорио цээрийн тухай хууль” түүнийг хэрэгжүүлэх журам (<http://www.customs.gov.cn/customs/302249/302266/302267/2369724/index.html>)
- “Хүнсний болон бусад бүтээгдэхүүний хяналт, удирдлагыг бэхжүүлэх талаар Төрийн зөвлөлийн тусгай журам” ([http://www.gov.cn/zwgk/2007-07/27/content\\_699138.htm](http://www.gov.cn/zwgk/2007-07/27/content_699138.htm))
- “Импортын болон экспортын махны хяналт шалгалт, хорио цээрийн байдалд хяналт тавих арга хэмжээ”. Гаалийн журам (<http://www.customs.gov.cn/customs/302249/302266/302267/2389611/index.html>)
- БНХАУ-ын хүнсний аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх журам ([http://www.gov.cn/zhengce/2020-12/27/content\\_5574156.htm](http://www.gov.cn/zhengce/2020-12/27/content_5574156.htm))

## БНХАУ-ын хүнсний импортыг зохицуулах байгууллагууд:

**Хүснэгт 8.** БНХАУ-ын хүнсний импортыг зохицуулах байгууллагууд


Байгууллага	Үүрэг чиглэл	Цахим хаяг
GAAC "Гаалийн ерөнхий газар"	«Гаалийн ерөнхий газар»-нь хүнсний импорттой холбоотойгоор дараах чиг үүргүүдээр үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортын хорио цээрийн дэглэм</li> <li>Ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортын хорио цээрийн дэглэм</li> <li>Гаалийн эрсдэлийн менежмент, статистик мэдээлэл</li> <li>Чөлөөт худалдааны бүсийн удирдлага</li> <li>Хүнсний бүтээгдэхүүний импортлогч байгууллагын бүртгэл</li> <li>Татвар хураалт</li> <li>Хилийн хяналт</li> <li>Олон улсын хамтын ажиллагаа, хоёр талын хэлэлцээрийг боловсруулж, гарын үсэг зурах.</li> </ul>	<a href="http://customs.gov.cn">http://customs.gov.cn</a> (Хятад хэлээр) <a href="http://english.customs.gov.cn">http://english.customs.gov.cn</a> (Англи хэлээр)
SAMR "Зах зээлийн удирдлага зохицуулалтын газар"	"Зах зээлийн удирдлага зохицуулалтын газар"-нь шинээр байгуулагдсан газар бөгөөд дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн зөвшөөрөл, лицензийн удирдлага</li> <li>Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний үйл явцын сертификат, зөвшөөрлүүд</li> <li>Зах зээлийн зохицуулалтыг нарийвчлан хэрэгжүүлэх</li> <li>Үндэсний хүнсний дээж, сорилын үйл ажиллагаа</li> <li>Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүн, нялхсын бүтээгдэхүүн</li> <li>Лабораторийн гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалт</li> <li>Үндэсний стандартчиллын тухай хууль тогтоомж, хууль тогтоомж гаргах, салбарын болон орон нутгийн стандартуудыг гаргах</li> <li>Барааны тэмдгийн бүртгэл.</li> </ul>	<a href="http://samr.gov.cn">http://samr.gov.cn</a> (Хятад хэлээр)
NHCC "Хятадын үндэсний эрүүл мэндийн комисс"	"Хятадын үндэсний эрүүл мэндийн хороо"-нь шинээр байгуулагдсан газар бөгөөд дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Хүнсний аюулгүй байдлын үндэсний стандартыг бий болгох</li> <li>Хүнсний шинэ түүхий эд, хүнсний шинэ нэмэлтийг бүртгэх</li> <li>Үндэсний стандартгүй бүтээгдэхүүний импортын зөвшөөрөл олгох</li> <li>Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ</li> </ul>	<a href="http://www.nhc.gov.cn/">http://www.nhc.gov.cn/</a> (Хятад хэлээр) <a href="http://en.nhc.gov.cn/">http://en.nhc.gov.cn/</a> (Англи хэлээр)

## Экспортлогч улс (бүс нутаг)-ын зөвшөөрөл:

Монгол улс, БНХАУ-ын засгийн газар хооронд "Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг 2009 онд байгуулж, хэлэлцээрийн 5 дугаар зүйлд тусгагдсан заалтын хүрээнд 2 жил тутамд хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын дэд сайд нарын төвшний хамтын ажиллагааны механизмаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбоотой асуудлыг шийдвэрлэдэг болсон.

### БНХАУ-ын зах зээлд мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйлдвэрийн хянан магадалгааны үйл явц

Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу холбогдох байгууллагууд хянан магадалгаа дараах байдлаар хийж гүйцэтгэнэ.



**Схем 1.** Хянан магадалгаа хийх үйл явц  
**Эх сурвалж:** Зөвлөх (судлаач)-ийн цуглуулсан чанарын мэдээлэл

БНХАУ-ын Гаалийн байгууллагын цахим хуудсанд мах махан бүтээгдэхүүний экспорт хийх бол дараах шаардлага хангасан байна гэж заасан (2020-09-03)

1. Хятад улс руу экспортлох мах махан бүтээгдэхүүний талаар бичгээр

гаргасан өргөдлийг БНХАУ -ын Гаалийн ерөнхий газарт албан ёсоор өгөх ёстой. Экспортлогч улсын малын хорио цээрийн нөхцөл байдлыг үндэслэн импортын үнэлгээ хийх эсэхийг Хятад улс шийддэг.

2. Мах экспортлох гэж буй улс нь улсын мал эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, зохицуулалтын систем, байгууллагын бүтэц, мал эмнэлгийн үйлчилгээний систем, чанарын хяналтын систем, үйлдвэрлэл зэрэг холбогдох технологийн мэдээлэл, эрүүл ахуйн аюулгүй байдлын хяналтын систем, үлдэгдлийг хянах систем, мал амьтны өвчний үзлэг, хяналт шинжилгээний байдал гэх мэт холбогдох мэдээллийг асуултад хариулах байдлаар өгөх ёстой.
3. Хятад улс экспортлох гэж буй тус улсын өгсөн санал асуулга, холбогдох мэдээллийн дагуу эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийдэг. Хэрэв үнэлгээгээр мах махан бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг эрсдэлийн зөвшөөрөгдөх хязгаарт багтсан гэж дүгнэвэл Хятад улс мэргэжилтнүүдээ экспортлогч орон руу илгээж газар дээр нь үзлэг хийнэ.
4. Хоёр тал Хятад улс руу экспортлох мах, махан бүтээгдэхүүний хяналт шалгалт, хорио цээрийн протоколын агуулгыг хэлэлцэн тохиролцож, эрүүл мэндийн гэрчилгээний агуулга, загварыг батлан хүлээн зөвшөөрөлцөнө.
5. Дээр дурдсан шалгалт, үнэлгээний дараа Хятадруу мах экспортлохоор бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний төрөл, болон бусад шаардагдах мэдээллийг өгч БНХАУ -ын Гаалийн Ерөнхий Газрын вэбсайтад нийтэлнэ.
6. БНХАУ -ын хилээр нэвтрэх амьтан, ургамлын хорио цээрийн зөвшөөрлийг авсны дараа импортлогчид хяналт, хорио цээрийн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнийг импортлох ёстой.
7. Мах, махан бүтээгдэхүүн БНХАУ -ын боомтод ирэхэд Хятадын гаалийн байгууллага хяналт, хорио цээрийн дэглэмийг хариуцна.
8. Түүнчлэн БНХАУ руу экспортолж буй махан бүтээгдэхүүн нь зэрлэг амьтдыг хамгаалах олон улсын дүрэм журмын шаардлагыг хангасан байх ёстой.

### **Экспортлогч цахим бүртгэлд хамрагдах, дугаар авах**

БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох компаниудад БНХАУ-ын "Гаалийн Ерөнхий Газар"-ын харьяа " Баталгаажуулалт итгэмжлэлийн газар"-аас үйлдвэр дээрх хянан магадалгаа хийх бөгөөд мах боловсруулах

үйлдвэрүүдэд энэхүү гарын авлагын 3.3 болон 3.4 БНХАУ-ын стандартууд болон хоёр орны хооронд байгуулагдсан протокол, мөн 3.1-д дурдсан Монгол Улсын холбогдох хууль, стандартуудын шаардлагуудыг хангасан байх шаардлага тавигдана.

Цахим бүртгэлийн маягт болон бүртгэлийн талаарх нэмэлт мэдээлэл авах, экспортлогчоор бүртгүүлэхдээ дараах цахим хуудсанд хандана уу. (<http://ire.customs.gov.cn>).

БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор хүсэлт гаргагч нь <http://www.cnca.gov.cn/bsdt/ywzl/jkspjwscpqzc/wjxz> линкээр орж өргөдлийн маягтыг татан авна.

Хэрэв экспортлогч компани нь БНХАУ-ын бүртгэлийн шаардлагыг хангасан гэж үнэлэгдсэн бол БНХАУ-ын Итгэмжлэл, Баталгаажуулалтын Газрын цахим хуудас (<http://www.cnca.gov.cn/bsdt/ywzl/jkspjwscpqzc>), эсвэл Гаалийн Ерөнхий Газрын цахим хуудас (<http://www.customs.gov.cn/customs/jyjj/dzwjyj/qymd/index.html>)-аар олон нийтэд мэдээлнэ.

БНХАУ Монгол улсаас тус улс руу мах экспортлох эрх бүхий 31 аж ахуйн нэгжүүдийн нэрсийг (2019оны 05 сарын байдлаарх) БНХАУ-ын гаалийн байгууллагын хуудсанд оруулж өгсөн байна.

### **БНХАУ-д экспортлох мах, махан бүтээгдэхүүний хорио цээр**

Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар хоорондын 2011 оны 10-р сарын 27-ны өдөр байгуулсан "Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай" протокол, 2016 оны 8 сарын 29 өдөр байгуулсан Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн махны хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай" протокол, "БНХАУ-д адууны мах экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай 2005 оны протокол"-уудад тусгасан бүтээгдэхүүнд тавигдах нийтлэг (ижил төстэй) шаардлагуудыг хангана.

### 3.4 Экспортод гаргах бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошго

**Сав, баглаа, боодлын стандарт, тусгай шаардлага:** Сав, баглаа, боодол, шошго тэмдэг нь хоёр орны хооронд хийгдсэн протоколуудад тусгасан шаардлагууд, Монгол улсын хууль тогтоомж, техникийн нөхцөл, холбогдох стандартууд, мөн импортлогч орноос тавьж байгаа мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагуудад нийцсэн байна.

Импортлогч орон руу гаргах боловсруулсан бүтээгдэхүүнийг олон улсын ариун цэврийн стандартыг хангасан шинэ материалаар боож баглана. Гадна баглаан дээр монгол, хятад, англи хэлээр үйлдвэрлэсэн газар, очих газар бүтээгдэхүүний нэр, жин үйлдвэрлэгчийн нэр, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаар, хадгалах нөхцөл, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, хоёр талаас тэмдэглэсний дагуу хяналт шалгалт, хорио цээрийн нөхцлийг хангасан тэмдэглэгээг заасан байна. Дотор баглаан дээр үйлдвэрлэгч орны нэр, бүтээгдэхүүний нэр, аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаарыг заасан байна. Дотор, гадна баглаан дээр мөн зөвхөн импортлогч оронд борлуулахыг заасан тэмдэглэгээг заавал хийнэ (тухайлбал, «зөвхөн Хятадын эх газарт борлуулна» «зөвхөн Монгол улсад борлуулна» гэх мэт).<sup>3</sup>

Мөн Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд холбогдох стандартын шаардлагуудыг хангах шаардлага тавигдана.

Манай улсад мөрдөгдөж байгаа сав, баглаа, боодлын стандартууд:

<b>MNS ISO 8367-2:1998</b>	Сав баглаа боодол - Ерөнхий зориулалтын уутны зөвшөөрөгдөх хэмжээ 2-р хэсэг: Нийлэг хальсан уут 2010 оны 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.
<b>MNS 6382:2013</b>	Сав баглаа боодлын зориулалттай үелээт картон. Техникийн шаардлага.
<b>MNS 5684:2006</b>	Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
<b>MNS OIML R 87:2008</b>	Савласан бүтээгдэхүүний тоо хэмжээ
<b>MNS ISO 780:2004</b>	Баглаа боодол - Эд зүйлсийг зөөвөрлөхөд тавих зурган тэмдэглэгээ
<b>MNS 1640:1973</b>	Сав. Үндсэн төрөл нэр томьёо.

БНХАУ-аас мах махан бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, шошго, тэмдэгт өөрийн орны стандартыг мөрдөх, мөн түүнчлэн хүнсний бүтээгдэхүүнд онцгойлон тодорхой шаардлагууд тавьдаг учраас экспортлогчдын хувьд нэн түрүүнд зорилтот зах зээлийн шаардлагыг хангах нь зайлшгүй юм.

<sup>3</sup> <https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/7rwc0qoc337woas/protokol.pdfw>

БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний стандартын газраас гаргасан бүтээгдэхүүний хаяглах, шошголох ерөнхий дүрэм, стандартыг дагаж мөрдөнө (National food safety standard General Rules for the labeling of prepackaged foods GB7718-2011). Энэхүү стандарт болон бусад стандартын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг БНХАУ-ын Үндэсний стандартын газрын албан ёсны цахим хуудаснаас авч болно (<https://www.chinesestandard.net>).

### Шошго, худалдааны тэмдэг, кодчилол

Савлагааны гаднах шошго: Хятад эсвэл Англи хэлээр байна.

1. Гарал үүсэл (Улс)
2. Бүтээгдэхүүний нэр
3. Очих улс
4. Үйлдвэрлэлийн лац дугаар (Үйлдвэрлэгчийн тодорхойлсноор)
5. Үйлдвэрлэсэн огноо
6. Цэвэр жин, килограммаар (Англи)
7. Дуусах хугацаа, хадгалах хугацаа
8. Үйлдвэрийн нэр
9. Үйлдвэрийн экспортлогчоор бүртгүүлсэн зөвшөөрлийн дугаар
10. Хөлдөөгөөд -18C хадгалсан
11. Үйлдвэрийн хаяг (Англи)
12. Хяналт хийсэн байгууллагын дардас (Англи). Монгол улсын хувьд энэ нь мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тэмдгийн дардас байх ба шошгын төв хэсэгт дарагдсан байна.

产地国家: 蒙古国 COUNTRY OF ORIGIN: <b>1</b>	产地名称: NAME OF PRODUCT: <b>2</b>
目的地: 中华人民共和国 DESTINATION: THE PEOPLE'S REPUBLIC OF CHINA <b>3</b>	
生产批号: PRODUCTION LOT <b>4</b>	生产日期 (年/月/日) PRODUCTION DATE <b>5</b>
净重 (公斤) : 20 NET WEIGHT : 20 <b>6</b>	保质期: 12个月 EXP: 12 MONTHS <b>7</b>
<b>8</b> 企业名称: 达尔汗肉食品有限公司 NAME OF PLANT: 	
工厂注册号: <b>9</b>	保持在-18度下冷藏 KEEP FROZEN AT -18C <b>10</b>
去也地址: ADDRESS OF PLANT: <b>11</b>	

Савлагааны доторх шошго: Хятад эсвэл Англи хэлээр байна.

1. Бүтээгдэхүүний нэр
2. Гарал үүсэл (Улс)
3. Байгууллагын дугаар
4. Үйлдвэрлэлийн лац дугаар (Үйлдвэрлэгчийн тодорхойлсноор)
5. Үйлдвэрийн бүртгэлийн дугаар

产品名称:冻马肉	1
NAME OF PRODUCT:	
产地国:蒙古国	2
COUNTRY OF ORIGIN:MONGOLIA	
马克肉制品进出口股份有限公司	3
NAME OF PLANT:	
MEAT PROCESSING FACTORY	
生产批号:	4
PRODUCTION BATCH No:	
工厂注册号:	5
PLANT REGISTRATION NO:	

## ДӨРӨВ. БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ҮЙЛ ЯВЦ

### 4.1 Гэрчилгээ, зөвшөөрөл

Монгол Улсын Засгийн Газраас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн Газрын 2020-2024 оны үйлжиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт, бичгүүдэд Монгол улсын эдийн засгийн тулгуур салбарын нэгээр Хөдөө аж ахуйн салбарыг тодорхойлж тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. ХХААХҮ-ийн сайд тухайн жилд экспортлох стратегийн хүнс, мах, махан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож зөвшөөрөл олгох тушаал гаргахдаа Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, гаргасан зөвлөмжийг үндэслэн БТКУС-ын ангиллын кодоор нарийвчлан тогтоодог. Экспортыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хонь, ямааны түүхий махны экспортын тоо хэмжээнд хязгаар тогтоогоогүй, БНХАУ-д итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүд яамтай Бодлогын гэрээ байгуулан экспорт хийнэ. Нэмүү өртөг шингэсэн хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилгоор эцсийн бүтээгдэхүүн экспортлох тохиолдолд ХХААХҮЯ-аас ямар нэгэн зөвшөөрөл авдаггүй.

Адууны мах, үхрийн мах, чанасан мах экспортлох тохиолдолд “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу сонгон шалгаруулалтад орж хуваарилагдсан тоо хэмжээний хүрээнд экспорт хийгддэг.

### Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ:

Мах экспортлох явцад хоёр удаагийн мал эмнэлгийн хяналтаар орно. Эхний удаад малчин, фермерээс экспортлогч, үйлдвэрлэгч хүрэх явцад анхан шатны мал эмнэлгийн нэгжийн хяналтад орж, “Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ” авах шаардлагатай. Хэрэв та мах бэлтгэлээ хариуцаагүй өөрийн үйлдвэрт хүлээж авч байгаа бол мал, махны гарал үүслийг баталсан дотоодын “Мал эмнэлгийн гэрчилгээ”-тэй эсэхийг нь заавал магадлаарай. Дараагийн шатанд “олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ” авна. Энэхүү дараалсан үйл ажиллагаа нь Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/67 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, “МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР, ХЭРЭГЛЭХ ЗААВРЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”-ын дагуу хийгдэнэ (<https://front.legalinfo.mn/main/detail/16207130851931>).



## Тохирлын гэрчилгээ

Стандарт, Хэмжил Зүйн Газраас экспортлогч нь тохирлын гэрчилгээ авах ба энэхүү гэрчилгээ нь экспортод гаргах бүтээгдэхүүн нь холбогдох стандартуудын дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна.

Үйлдвэрлэгч СХЗГ-д дараах материалуудыг бүрдүүлж өгнө. Эдгээр нь:

1. Иргэн аж ахуйн нэгжийн хүсэлт, албан тоот, өргөдөл - /маягт 1-ийн дагуу/
2. Иргэний цахим үнэмлэхийн хуулбар /хувь хүн/, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Худалдах, худалдан авах гэрээ
4. Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг
5. Бүтээгдэхүүнд сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ сорилтын дүн
6. Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл /зөвхөн шаардлагатай тохиолдолд/
7. Үйлчилгээний төлбөр тушаасан баримт

Тохирлын гэрчилгээ авахдаа [www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn) цахим хуудсанд хандаж дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

## Гарал үүслийн гэрчилгээ:

Хоёр төрлийн гарал үүслийн нотолгоо, гэрчилгээний талаар энд дурдах шаардлагатай.

Эхний ээлжид танай үйлдвэр махаа Монгол Улсын аль аймгаас бүр нарийвчилбал хэн гэдэг малчны хотноос, хоршооноос, мах нядалгааны газраас бэлтгэсэн болохыг харуулах. Энэ тухай дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ авах хэсэгт дурдсан. Дараагийн шатанд БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор зөвшөөрөгдсөн бүс нутаг болох Монгол Улсаас гарал үүсэлтэй болохыг баталсан гэрчилгээг авах шаардлагатай. Энэ гэрчилгээ нь БНХАУ-ын импортын шаардлагын дагуу тухайн бүтээгдэхүүн Монгол Улсад үйлдвэрлэгдсэн гэдгийг экспортлогч баталгаажуулах ёстой.

Энэхүү гэрчилгээг МҮХАҮТ-ээс авах бөгөөд дараах дөрвөн алхмын дагуу гэрчилгээг олгоно: Эдгээр нь:

- Алхам 1: Үндсэн бичиг баримт бүрдүүлнэ
- Алхам 2: Онлайнаар хүсэлтээ илгээнэ
- Алхам 3: Төлбөр төлөлт, мэдээллээ өгнө
- Алхам 4: Материалууд авч ирэх, гэрчилгээ авах

Алхам тус бүрд анхаарах асуудлын талаар Та МҮХАҮТ-ийн <https://www.mongolchamber.mn/p/60> цахим хуудаснаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

## Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ

Экспортлогч нь МЭЕГ-аас мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авна (<https://front.legalinfo.mn/main/detail/16207130851931>). Энэхүү гэрчилгээ нь эрүүл мэнд, мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна. Энэхүү гэрчилгээг авахад экспортлогч нь албан хүсэлтийг дараах бичиг баримтын хамт бүрдүүлж, МЭЕГ-т өгнө.

1	Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт, мал эмнэлгийн гэрчилгээ
2	Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг
3	Хүсэлт гаргагч нь хуулийн эдгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбар
4	Хүсэлт гаргагч нь мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа
5	Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, хэмжээ, боловсруулалтын байдал (хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, загсаасан, шинэ гэх мэт) савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл
6	Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил

**Зураг 31.** Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад бүрдүүлэх материал  
**Эх сурвалж:** МЭЕГ, [www.vet.gov.mn](http://www.vet.gov.mn)

## Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ

Экспортлогч нь МЭЕГ-аас олгосон "Мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ"-нд үндэслэн ГЕГ-аас Монгол Улсаас БНХАУ-д экспортлох мах, махан бүтээгдэхүүний "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ" (экспортын гэрчилгээ) авна. Энэхүү гэрчилгээг авах дэлгэрэнгүй зааврыг <https://www.caps.gaali.mn> цахим хуудсанд байрлуулсан байгаа.

## 4.2 Тээвэрлэлт

БНХАУ-руу мах, махан бүтээгдэхүүн экспортлогчид нь ихэвчлэн авто замын тээврийг ашиглаж байна. Тээвэрлэлтийг хөргүүртэй, чингэлэгтэй, гаалийн итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслээр хийнэ.



Зураг 32. Тээврийн дагалдах бичиг баримт

## 4.3 Гаальтай холбоотой процесс

### Экспортын гаалийн процесс

Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах бичиг баримт:

- Гаалийн тухай хуулийн 60-р зүйлд заасан:
  - Гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;
  - Тээврийн бичиг баримт;
  - Тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;
- Хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт

- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8.2-д заасан:
- Мэдүүлэгчийн гаргаж өгсөн бичиг баримт нь гаалийн үнийг шалгаж, шийдвэр гаргахад хангалтгүй гэж үзвэл гаалийн байгууллага мэдүүлэгчээс нэмэлт мэдээлэл, бичиг баримт гаргуулан авч болно.

### Барааг гаальд мэдүүлэх үйл ажиллагаа

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаарх шаардлагатай бүх мэдээллийг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу бичиж, холбогдох бичиг баримтын хамт гаалийн байгууллагад өгнө.

Гаалийн мэдүүлгийн маягт, түүний бүтцийг Гаалийн Ерөнхий Газрын <https://www.customs.gov.mn/2014-03-25-01-15-34> цахим хуудасны гаалийн бүрдүүлэлт хэсгээс харна уу.

### Гаалийн хяналт шалгалт

**Гаалийн хяналтын төлөв нь** улаан, улбар шар, ногоон өнгөөр тодорхойлогдох ба дараах утга санааг илэрхийлнэ. Үүнд:

Улаан: Биет шалгалт, бичиг баримтын шалгалт хийгдэнэ.

Шар: Зөвхөн бичиг баримтын шалгалт хийгдэнэ.

Ногоон: Биет шалгалт, бичиг баримтын шалгалт хийгдэхгүй.

### Гаалийн хяналт, шалгалтын төрөл:

- Гаалийн хяналтын бүс дэх хяналт, шалгалт
- Гүний гаалийн хяналт, шалгалт

### Барааны ангилал тодорхойлох

Экспортод гаргах бүтээгдэхүүнийг БТКУС-д үндэслэн:

- Экспортод гарахаас өмнө,
- Мэдүүлэх явцад,
- Бүрдүүлэлтийн дараах шатанд тодорхойлж болно.

### Гаалийн үнэ, тариф

Экспортын барааны гаалийн үнийг Монгол Улсын "Гаалийн тариф, гаалийн татварын тухай" хуулийн 3.1.4-д үндэслэн тодорхойлно.


### Экспортын барааны гаалийн үнэд:

Гэрээ хэлцлийн үнэ + Монгол Улсын хил хүртэл уг барааг хүргэхэд гарах тээврийн зардал + Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн болон экспортын бичиг баримт, бүрдүүлэлтийн хураамж + Даатгалын шимтгэл + Барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачихад гарсан зардлууд багтана.

Гаальд бараагаа мэдүүлэх үедээ мэдүүлэгч гаалийн үнийг өөрөө тооцон тодорхойлох, мэдүүлэх журамтай.

### Импортлогчийн гаалийн процесс:

БНХАУ руу мах махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжийг хэрхэн үнэлж, экспортын зөвшөөрөл олгох, бүтээгдэхүүн импортлох талаар БНХАУ гаалийн байгууллагын цахим хуудсаараа дамжуулан мэдээлэл өгдөг. Дараах линкээр 09/03/2020 өдрийн шинэчлэгдсэн мэдээллийг нэвтэрч үзэх боломжтой. <http://english.customs.gov.cn/Statics/3efe2268-3f15-4013-872a-39da26f93b1c.html>. Импортлогчийн бараа хүлээн авах ерөнхий схемийг дараах зураглалаар харуулав.



CIQ – China Entry – Exit inspection & Quarantine Bureau / БНХАУ-ын хилийн хяналт, шалгалт хорио цээрийн алба  
 CFDA – China Food and Drug Administration / БНХАУ-ын хүнс, эмийн бүтээгдэхүүний удирдах газар  
 CNCA – Certificate & Accreditation Administration of China / БНХАУ-ын гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалтын газар  
 MOA – Ministry of Agriculture / БНХАУ-ын хөдөө, аж ахуйн яам  
 MOFCOM – Ministry of Commerce / БНХАУ-ын худалдааны яам  
 AQSIQ – Administration of Quality Supervision, Inspection and Quarantine / БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар  
 GACC – General Administration of Customs / БНХАУ-ын гаалийн ерөнхий газар

Зураг 33. Импортлогчийн бараа хүлээн авах үе шат

### Импортын тариф:

- HS>160290 бэлтгэсэн буюу хадгалсан мах, дотор эрхтэн, цус, HS>160250 хатаасан үхрийн мах, HS>160100 хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мах, гэдэс дотрын болон цус; эдгээр бүтээгдэхүүнд суурилсан хүнсний бэлдмэл бүтээгдэхүүний импортын татвар 5%;
- HS <020442 кодтой хөлдөөсөн хонь, ямааны ястай мах 12%;
- HS <020422 хонины шинэ буюу хөргөсөн зүсмэл, ястай мах, HS <230910 Гэрийн тэжээвэр амьтдын хоол тус 15%;
- HS <020690 хонь, ямаа, адууны хөлдөөсөн мах 18%;
- HS>020441 хөлдөөсөн хонины гулууз, хагас гулууз 23%;
- HS <021020 давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан үхрийн мах 25% импортын татвартай байна.

Эдгээр бүтээгдэхүүнээс хамгийн бага татвартай, нэмүү өртөг шингэсэн, боловсруулсан бүтээгдэхүүн HS>160290, HS>160250, HS>160100 бүтээгдэхүүнүүд экспортлох боломж өндөр байна.

### ТАВ. БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД АНХААРАХ АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол улсын хувьд бэлчээрийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний экспортын хувьд харьцангуй давуу талтай байна. Мах, махан бүтээгдэхүүний экспортод тулгарч буй бэрхшээл нь: мал амьтны халдварт өвчний дэгдэлт, бүтээгдэхүүний гарал, үүслийг баталгаажуулж чадахгүй байгаа байдал, мэргэжилтэй ажиллах хүчний дутагдал, үйлдвэрийн тоног төхөөрөмж, тоноглолын хоцрогдол, чанарын баталгаажуулалт хяналтын бүрэн бус байдал зэрэг байна.

Эдгээр асуудлуудыг шат дараатайгаар шийдвэрлэж чадсан тохиолдолд БНХАУ-д энэхүү гарын авлагад дурдагдсан бүтээгдэхүүнүүдийг харьцангуй өндөр өртгөөр тогтвортой нийлүүлэх боломжтой байна.

Үүний тулд мах боловсруулах үйлдвэр, экспортлогчдод дутагдаж буй үйл ажиллагааны зардал, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг шийдвэрлэх тогтвортой, нээлттэй бодлого хэрэгжүүлэх. Мөн төрийн байгууллагуудаас экспортын зөвшөөрөл олгох хүнд суртлыг арилгах, шат дамжлагыг бууруулах нь нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал болж байна. Мөн нөгөө талаас экспортын компаниуд олон улсын болон дотоодын зайшгүй мөрдөж биелүүлэх шаардлагатай дүрэм журам, бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд цаг тухайд нь биелүүлэхэд анхаарч төр, хувийн хэвшлийн нэг зүгт чиглэсэн хамтын ажиллагааг хэвшүүлэх нь мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мах экспортын тогтвортой байдлыг хангах, мах экспортын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор экспортлогчдод дараах зөвлөмжийг өгч байна. Эдгээр нь:

1. Мал бэлтгэлийг Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг МЭЕГ-аас баталгаажуулсан өвчингүй, эрүүл, тайван бүсээс бэлтгэх, батлах.
2. БНХАУ-ын хууль зүйн хувьд баталгаатай, улсдаа бүртгэлтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй импортлогчтой сайн түншийн харилцаа бий болгох.
3. БНХАУ дахь засгийн газар, зах зээлийн мэдээллийг анхааралтай ажиглаж, аливаа гэнэтийн шийдвэр, шаардлага, бодлогын өөрчлөлтөд бэлэн байх, энэ талаар түнштэйгээ хамтран ажиллах.
4. БНХАУ-ын хилийн боомтоос хамааран гарах зардал өөрчлөгдөх магадлалтай тул аль болох нэг хилийн боомтоор дагнан экспорт хийх нь цаг хугацаа болон зардал хэмнэхэд тустай.

5. БНХАУ-ын зах зээлд өөрөө орж ажиллах боломжийг эрэлхийлэх (Одоогоор экспортлогчид БНХАУ-ын импортлогчидтой гэрээ хийн ажиллаж байгаа бөгөөд импортлогч нь БНХАУ-ын гаалийн газраас мах, махан бүтээгдэхүүн импортлох зөвшөөрөлтэй этгээд байхаар зохицуулагдаж байна.)
6. Зах зээлийн сегментээ зөв сонгох. Өндөр орлоготой хэрэглэгчдийн сегментэд хүрч ажиллах. БНХАУ-ын зах зээлд өндөр орлоготой хэрэглэгчид (Walmart, Carrefour, CR Vanguard, Suguo, Ole, Sam's club, BHG, Century Mart, RT Mart, Yonghui) зэрэг томоохон сүлжээ супермаркетууд, дээд зэрэглэлийн хайпермаркетуудаар үйлчлүүлж байна. Иймээс эдгээр сүлжээ супермаркетуудтай холбоо тогтоох, импортлогч түнштэйгээ хамтарч ажиллах.
7. Боловсруулсан бүтээгдэхүүн экспортлоход голлон анхаарах зүйл нь тухайн нутгийн хэрэглэгчдийн хүсэлд нийцсэн амтыг гаргах мэргэжилтэн, технологичтой байх.
8. Үйлдвэрүүдийг хянан магадлах Хятадын талын шинжээчдийн тавьж буй шаардлагуудыг онцгой анхааран, ширхэгчлэн биелүүлэх.
9. БНХАУ-д бүтээгдэхүүнээ нийлүүлэх үед сав, баглаа боодлын зөрчил илэрвэл цаашид "шалгах шаардлагатай компаниуд"-ын жагсаалтад орж гаалийн бүрдүүлэлтэд цаг алдах, бүтээгдэхүүн нь буцаагдах эрсдэл бий болдог тул бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг хоёр улсын худалдааны шаардлагын дагуу хийх.
10. Шинэ дижитал технологи, цахим арилжааны системийг ашиглахыг эрмэлзэх.
11. Монгол улсын мах, махан бүтээгдэхүүний брэнд бий болгох.

## **ЗУРГАА. БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ**

### **Монголын талаас шаардлагатай баримт бичгүүдийн жагсаалт**

1. Мал эмнэлэг, хорио цээрийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
2. Мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
3. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (экспортын гэрчилгээ), шаардлагатай бичиг баримт (ГЕГ)
4. Гарал үүслийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МҮХАҮТ)
5. Итгэмжлэлийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
6. Тохирлын гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (СХЗГ)
7. Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл, шаардлагатай бичиг баримт (ХХААХҮЯ)
8. Гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримт (ГЕГ)

### **БНХАУ-ын талаас шаардлагатай баримт бичгүүдийн жагсаалт**

Экспортлогчоор бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

1. Компанийн талаарх мэдээлэл
2. Өргөдлийн маягт бөглөсөн байх
3. Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ гэх мэт
4. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)

### **БНХАУ-ын Гаалийн байгууллагад шаардлагатай бичиг баримтын жагсаалт:**

1. Төлбөрийн нэхэмжлэх
2. Сав баглаа боодлын жагсаалт
3. Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
4. Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл
5. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ)
6. Ачааны манифест

## ДОЛОО. БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

### 7.1 Монгол Улс болон БНХАУ-ын талаас оролцогч ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

- Монгол Улсын ЗГ, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 13381 Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн Газрын IX байр  
Утас: 51-262271  
Цахим хуудас: <http://mofa.gov.mn/>
- Монгол Улсын Мал Эмнэлгийн Ерөнхий Газар  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 13381 Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр  
Утас: 51-262482  
Цахим хуудас: <http://vet.gov.mn/>
- Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар  
Хаяг: Засгийн газрын XII байр Барилгачдын талбай-13 Улаанбаатар  
15170  
Утас: 51-264786  
Цахим хуудас: <http://home.inspection.gov.mn/>
- Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар  
Хаяг: Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар, Сүхбаатар дүүрэг, Их  
тойруу 81/1 Улаанбаатар-14193  
Утас: 11- 350049  
Цахим хуудас: <http://customs.gov.mn/>
- Монгол Улсын Стандарт Хэмжил Зүйн Газар  
Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 46А Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот.  
13343  
Утас: 11-458349  
Цахим хуудас: <https://masm.gov.mn/>

- Нийслэлийн Мал Эмнэлгийн Газар  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 р хороо,  
Чингүүнжавын гудамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын байр.  
Утас: 70144009, 70144007  
Цахим хуудас: <http://vet.ub.gov.mn/>
- БНХАУ-ын Гаалийн Ерөнхий Газар (GACC)  
Хаяг: No. 6 Jianguomennei Avenue, Dongcheng District, Beijing, China  
Шуудангийн код: 100730  
Утас: 010-65194114  
Цахим хуудас: <http://nhfpc.gov.cn>, <http://en.nhfpc.gov.cn>
- БНХАУ-ын Зах Зээлийн Удирдлага, Зохицуулалтын газар (SAMR)  
Хаяг: No. 8 Sanlihe East Road, Xicheng District, Beijing, China  
Шуудангийн код: 100820  
Утас: 010-88650000  
Цахим хуудас: <http://www.samr.gov.cn/>
- БНХАУ-ын Эрүүл Мэндийн Үндэсний Комисс (NHCC)  
Хаяг: No. 1 Xizhimen Outer South Road, Xicheng District, Beijing, China  
Шуудангийн код: 100044  
Утас: 010- 68792114  
Цахим хуудас: <http://www.nhc.gov.cn/> , <http://en.nhc.gov.cn/>
- БНХАУ-ын Баталгаажуулалт, Итгэмжлэлийн Газар (CNCA)  
Хаяг: No. 9 Madian East Road, Haidian District, Beijing, China  
Шуудангийн код: 100088  
Утас: 010-58116300  
Цахим хуудас: <http://www.cnca.gov.cn/>
- БНХАУ-ын Стандартын Удирдлагын Газар (SAC)  
Хаяг: No. 9 Madian Doglu, Haidian District, Beijing, China

Шуудангийн код: 100088

Утас: 010-82262609

Цахим хуудас: <http://www.sac.gov.cn/>

## 7.2 Монгол Улс болон БНХАУ-ын талаас оролцогч ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим  
Хаяг: Улаанбаатар хот, 17011, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, МҮХАУТ-ын байр.  
Утас: 77277070  
Цахим хуудас: <https://www.mongolchamber.mn/>  
И-мэйл: [info@mongolchamber.mn](mailto:info@mongolchamber.mn)
- Монголын Махны Холбоо  
Утас: 99113938
- Монголын Экспортлогчдын Холбоо  
Утас: 99119356  
Цахим хуудас: <https://vip76.mn/organization/173>
- БНХАУ-ын All-China Federation of Industry and Commerce (ACFIC)  
Хаяг: No.70, West Deshengmen Street, Xicheng District, Beijing, China  
Шуудангийн код: 100035  
Утас: 0086-10-58050500  
Цахим хуудас: <http://www.chinachamber.org.cn/>

## 7.3 Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газраас итгэмжлэгдсэн тээврийн компаниуд

Экспортын тээвэрт гаалийн итгэмжлэгдсэн тээврийг ашиглах бөгөөд 2019.11.18-ны байдлаар нийт 190 тээврийн компани ГЕГ-т бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр компаниас мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлтэй компанийг сонгон үйлчлүүлээрэй. Дараах холбоосыг ашиглан гаалийн итгэмжлэгдсэн тээврийн зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг авна уу ([www.customs.gov.mn/images/publishers/GIT\\_](http://www.customs.gov.mn/images/publishers/GIT_)

[jagsaalt\\_2019.11.18.pdf](#)). Мөн түүнчлэн гадаад худалдааны портал сайт <http://www.mongoliatradingportal.com/> -аас мах, махан бүтээгдэхүүний HS кодоор хайлт хийж ямар компани аль төрлийн бүтээгдэхүүний зөвшөөрөлтэй байгааг харж болно. Мөн энэ сайтаас тухайн кодын бүтээгдэхүүнтэй холбоотой хууль эрх зүйн орчинтой танилцах боломжтой.

## 7.4 БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн импортлогч томоохон компаниуд

Компанийн нэр	Бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ	Ажилчдын тоо	Байршил
Angliss Beijing Food Service Limited	2	170	Beijing
Danish Crown (China) Co., Ltd.	2	50	Jiaxing
Hormel (China) Investment Co., Ltd.	1	20	Jiaxing
Inalca Food & Beverage Co., Ltd.	2	15	Zhongshan
Keystone Food Services Co., Ltd.	2	1500	Shenzhen
Kuze (Chengdu) Trading Co., Ltd.	3	14	Chengdu
Nichirei Corporation Shanghai Limited	2	20	Shanghai
Qingdao Chia Tai Co., Ltd.	2	1707	Qingdao
Shanghai Taiyang Rongguang Commerce Co., Ltd.	1	32	Shanghai
Tengzhou Dongqi Meat Processing Co., Ltd.	2	600	Tengzhou
Ushio Zhenzhen Inc.	2	50	Shenzhen
VION Food International China	1	12	Shanghai

## НАЙМ. КОРОНА ВИРУСИЙН ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 8.1 Олон улсад ба БНХАУ-д

Коронавирусын цар тахал гарсантай холбоотойгоор олон улсын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод тавигдах шаардлагыг боловсруулан улс орнуудад мөрдөж хянаж ажиллахыг зөвлөж байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хамтран «Шинэ коронавирус ба хүнсний аюулгүй байдал: Хүнсний үйлдвэр эрхлэгчдэд зориулсан удирдамж» боловсруулан гаргасан бөгөөд энэхүү удирдамжид хүнсний үйлдвэрүүдэд дараах удирдамжуудыг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

Хүнсний үйлдвэр нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг удирдах, хүнсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй байдлыг хянах цэгийн тогтолцоо" (НАССР), "Хүнсний аюулгүй

байдлын удирдлагын систем” (FSMS) -тэй байх ёстой. Тус удирдамжид дараах бүлэг шаардлагуудыг тусгасан байна.

- Хүнсний үйлдвэрийн ажилчдад COVID-19-ийн шинж тэмдгүүдийн талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах, сургалт явуулах, заавар зөвлөмж өгөх.
- Ажлын орчинд COVID-19 тархахаас урьдчилан сэргийлэх дадлыг бүрдүүлэх, хэвшүүлэх.
- Хүнсний үйлдвэрийн ажилчид нэг удаагийн бээлий ашиглах
- Хүнсний орц, хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хүргэх явцдаа халдвар, хамгаалал, ариун цэврийн зохих протоколыг мөрдөнө.
- Жижиглэнгийн худалдааны байранд зай барих, үйлчлүүлэгчдийн тоог зохицуулах, халдвар хамгаалал, ариун цэврийн дэглэмийг сахиулах.
- Худалдааны тавиур, лангууны халдвар хамгаалал, ариун цэврийн дэглэмийг хангах.
- Ажилчдын хоолны газрын халдвар хамгаалал, ариун цэврийн дэглэмийг хангах.

БНХАУ-ын хувьд мах, махан бүтээгдэхүүний гинжин хэлхээн дэх үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалт, экспорт, импортод тавигдах шаардлага, хяналт, шалгалтыг эрчимжүүлж байна. БНХАУ-д импортлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд тавигдах “Шинэ коронавирус ба хүнсний аюулгүй байдал: Хүнсний үйлдвэр эрхлэгчдэд зориулсан удирдамж”-ийг дараах холбоосуудаар орж танилцах, татаж авах боломжтой.

- <http://jckspj.customs.gov.cn/spj/zwgk75/2706880/3066487/index.html>,
- [WHO-2019-nCoV-Food\\_Safety\\_businesses-2020.1-eng.pdf](#),
- [新冠肺炎和食品安全: 对食品企业指南-参考译文.pdf](#)

БНХАУ шинэ коронавирусын цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор тус оронд бүтээгдэхүүнээ экспортолдог гадаад дахь үйлдвэр, компаниудаас “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах тухай хууль” ([http://www.moj.gov.cn/subject/content/2020-02/14/1449\\_3241666.html](http://www.moj.gov.cn/subject/content/2020-02/14/1449_3241666.html)), “Хилийн эрүүл мэнд, хорио цээрийн тухай хууль” (<http://cs.mfa.gov.cn/zlbg/flfg/crjxg/t266914.shtml>) -ийн холбогдох заалтуудыг чанд сахиж мөрдөхийг шаардаж байна.

Мөн импортын хөлдүү хүнснээс коронавирусын сорьц эерэг гарсантай холбоотойгоор хөлдүү хүнсний импортод тавих хяналт шалгалтаа чангатгаж “Хүйтэн гинжин хэлхээ бүхий хүнсний үйлдвэрлэл, ашиглалтын үеийн шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянах техникийн удирдамж”-

ыг боловсруулан мөрдүүлж байна. “Хүйтэн гинжин хэлхээ бүхий хүнсний үйлдвэрлэл, ашиглалтын үеийн шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянах техникийн удирдамж”-ыг дараах холбоосоор орж танилцах боломжтой ([http://www.gov.cn/xinwen/2020-10/27/content\\_5555114.htm](http://www.gov.cn/xinwen/2020-10/27/content_5555114.htm)).

Тус удирдамжид дараах бүлэг шаардлагуудыг тусгасан байна.

1. Ажилчдын коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянах эрүүл мэндийн менежмент
2. Ачих, буулгах, хадгалах, тээвэрлэх явцад коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянахад тавигдах шаардлага
3. Үйлдвэрлэл, боловсруулалтын явцад коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянахад тавигдах шаардлага
4. Борлуулалтын үйл ажиллагаанд коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянахад тавигдах шаардлага
5. Нийтийн хоолны боловсруулалт, үйл ажиллагаанд коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянахад тавигдах шаардлага
6. Коронавирусын халдварын үед авах арга хэмжээг тусгажээ.

Бүлэг шаардлагуудын зарим зүйл заалтаас дурдвал:

- Хөлдөөсөн бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэгчид, операторууд ажилчдынхаа 14 хоног доторх хөдөлгөөний маршрут, эрүүл мэндийн байдлыг (шинэ ажилд орсон болон түр ажилчдыг оролцуулан) бүртгэлжүүлэх, жижүүрлэн ажиллагсдын эрүүл мэндийн картыг бүрдүүлэх, ажилчдын урсгалыг бүртгэлтэй байлгах. Шинээр ажилтан авахдаа шинжилгээ хийлгэсэн байх; Үйлдвэрийн ажилчдын халууныг тогтмол хэмжих, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагуудыг мөрдөж ажиллуулах зэргээр ажилчдын эрүүл мэндийн бүртгэлийн системийг бий болгох, ажилчдын өдөр тутмын эрүүл мэндийн хяналт, үйлдвэрт нэвтрэх гаднын хүмүүсийн бүртгэл, менежмент, дадлагажигчдын эрүүл ахуйн шаардлага, эрүүл мэнд хэвийн бус байдлыг мэдээлэх, өвдөөд эдгэж ирж буй ажилчдыг ажилд нь эргүүлэн ажиллуулах, урьдчилан сэргийлэх, хянах мэдлэгийг сурталчлах ажлыг бэхжүүлэх талаар заалтууд оруулжээ.
- Тээвэрлэлтийн үед ачааг нээхгүй, газар тавихгүй, импортолсон бүтээгдэхүүн бол дээж, холбогдох бичиг баримтыг хавсаргасан байх, шаардлагагүй хүмүүстэй уулзахгүй байх, бүтээгдэхүүнийг ачих буулгах үедээ хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсөх, цэвэрлэх



халдваргүйжүүлэх талаар нарийвчилсан заалтууд тусгагдсан байна.

БНХАУ “Хүйтэн гинжин хэлхээ бүхий хоол, хүнс үйлдвэрлэх, ашиглах үйл явцад шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, хянах, халдваргүйжүүлэх техникийн заавар”-ыг боловсруулж ариутгал, халдваргүйжүүлэлт хийхдээ тус техникийн зааврыг дагаж мөрдөхийг зөвлөж байна. Уг зааврыг дараах холбоосоор орж үзнэ үү ([http://www.gov.cn/xinwen/2020-10/27/content\\_5555114.htm](http://www.gov.cn/xinwen/2020-10/27/content_5555114.htm))

Тус техникийн зааварт дараах бүлэг шаардлагуудыг тусгасан байна.

- Үйлдвэрлэл, боловсруулалтын явцад ариутгах, халдваргүйжүүлэх
- Тээвэрлэх, түгээх явцад ариутгах, халдваргүйжүүлэх
- Борлуулалтын үйл ажиллагааны явцад ариутгах, халдваргүйжүүлэх
- Нийтийн хоолны боловсруулалтын үйл ажиллагаанд ариутгах, халдваргүйжүүлэх
- Үйлдвэрлэл, ашиглалтын явцад түгээмэл хэрэглэгддэг ариутгагч бодисууд

БНХАУ тус улсад хүйтэн гинжин хэлхээ бүхий хоол, хүнс экспортолдог улс орнуудын аж ахуй нэгжүүдэд үйлдвэрлэлийн хүнсний аюулгүй байдлын менежментийн системээ сайжруулж, БНХАУ-д экспортолж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг шаардаж, хяналт тавин ажиллаж байна.

Мөн алсын зайн видео хяналт хийх, НҮБ-ын хүнс хөдөө аж ахуйн байгууллага, дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан удирдамжийг дагаж мөрдөх, зарим нэгэн кластер хэлбэрээр тархаж байгаа улс орны үйлдвэрүүдийн импортыг зогсоох зэрэг арга хэмжээ авсан байна. Эдгээрт мах боловсруулах үйлдвэрийн ажилчдаас нь Ковидын халдвар авсан тул Аргентин, Канад, Ирланд, Франц, Бразил, Итали, Недерланд, Герман, АНУ, Англи улсууд Хятад руу мах экспортлохоо зогсоосон байна. Гэхдээ Ковидын нөхцөл байдал хяналтад орсны дараа улс орнуудаас мах импортлох хоригоо цуцалж байгаа ч удаашралтай байгаа талаар мэдээлжээ. Дэлхийн худалдааны байгууллагаас хүнсний бүтээгдэхүүнээр ковидын халдвар дамжихгүй тул ковид гарахаас өмнөх үеийн шаардлагатай ижил шаардлага тавих хэрэгтэй гэж байгаа ч Хятадын тал хориг тавьсаар байна. (Source: <https://www.thepigsite.com/news/2020/08/reader-q-a-why-has-china-suspended-imports-from-some-foreign-meat-processors>; <https://www.thepoultrysite.com/news/2020/06/china-bans-imports-from-another-three-covid-19-affected-plants-in-brazil>; <https://www.ft.com/content/915b7a63-bc2b-4cdf-909d-d375a29a4129>; <https://www.reuters.com/article/health-coronavirus-china-meats-idUSL4N2ED1B8>).

## 8.2 Монгол улсад

Монгол улс корона вирусын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг бууруулах зорилгоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” (<https://www.legalinfo.mn/law/details/15312>)-ийг батлан хэрэгжүүлж байна. Махны үйлдвэрлэл нь хүнс үйлдвэрлэлийн ангилалд багтаж байгаа тул тасралтгүй ажиллах боломжтой байв. 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор, хил хааж Хятад иргэдийн зорчих хөдөлгөөн хязгаарлагдсан тул махны экспорт зогсонги байдалд оров. Ингэснээр агуулахад хадгалагдаж байгаа махны үлдэгдлийн хэмжээ их болсон. 2020 онд бэлтгэгдсэн экспортын мах хадгалагдаж байгаад 2020 он 12-р сар, 2021 оны 1-р саруудад ачигдаж эхэлснээс Замын-Үүдийн боомт дээр махны тээврийн ачааны машины бөөгнөрлийг үүсгэлээ. Экспортлогч компани гаалийн мэдүүлгээ цахимаар өгч болох болсноор түүнд зарцуулдаг цаг богиносгох боломж бүрдсэн ч хил гааль дээрх ариутгалын үйлчилгээ Монголын болон Хятадын тал аль аль нь удаашралтай байна.

## 8.3 Ковид-19 цар тахалтай холбоотой махны экспортын нөхцөл байдал

Ковидын үед дунджаар өдөрт зургаа орчим мах тээврийн машин Хятадын хилээр нэвтэрч байв. 2020 оны 12 сар, 2021 оны нэгдүгээр сард мах ачиж очсон машинууд 2 сар орчим хүлээсэн. Ковидын үеийн хилийн тээврийн зохицуулалтыг хийхдээ Замын Үүд хил дээрээс Монгол жолооч ачаагаа ачин Хятадын талын агуулахын үүдэнд буулгах ба тэндээс гаалийн бүрдүүлэлтийн хүн жолоочтой нь авч яваад Хятадын гаалийн талбайд тавина. Хятадын тал гаалийн бүрдүүлэлт хийсний дараа Хятад жолооч хүлээн авч агуулахад буулгаад буцаад гаалийн талбайд тавих ба Монгол жолооч аваад хил дээр авчирна. Тэндээс өөр жолооч махыг тээвэрлэн авчирч өгнө. Ийнхүү олон шат дамжлага дамжиж олон хоног болж байгаагаас эд зүйлсийн хулгай, эвдрэл, зардал хэт өндөр гарах зэрэг бэрхшээл байнга гарсаар байна. Дунджаар нэг удаагийн ачилт буулгалтын зардал 6 сая төгрөг, хүлээлтийн хоёр сарын буудлын хөлсийг тооцоолохоор махны экспорт ашиггүй болж байна. Эдгээр зардлаас гадна ачаа ачих болгондоо PCR шинжилгээ өгөх нь чирэгдэл, зардал ихтэй. Мах экспортын протокол, хэлэлцээрт өөрчлөлт ороогүй. Хоёр талын үйлдвэрүүд Ковидын үед баримтлах дотоод журмыг гарган мөрдөж ажиллаж байна. Экспортын бүх бүтээгдэхүүн, сав баглаа боодол, тоног төхөөрөмжөөс Ковидын шинжилгээ авч байгаа нь мөн цаг хугацаа, зардлыг өсгөхөд нөлөөлж байна.

Махны экспортыг нэмэгдүүлэх, экспортлогч компаниудын тоог нэмэгдүүлэх хүсэлтийн дагуу БНХАУ-ын талаас 2021 оны 3 сард цахимаар Монголын талын дөрвөн компанид магадлан итгэмжлэл хийсэн боловч үйлдвэрүүдээс Хятадын талын шаардлага хангасан компани гарсангүй. Уг магадлан итгэмжлэлийг МХЕГ, ГХЯ, ХХААХҮЯ, МЭЕГ зэрэг байгууллагын төлөөлөл оролцон хийсэн тул манай талаас анхаарч үйлдвэрүүдтэйгээ хамтран ажилласнаар Хятадын талаас тавьсан шаардлагуудыг хангаж дахин магадлуулна гэсэн хүлээлттэй байна.

